



ГОЛОМТ БАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2009





ГОЛОМТ БАНК ЖИЛИЙН ТАЙЛАН 2009



Агуулга

2	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
4	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
8	ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ
14	БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ
14	Хэтийн зорилго, Эрхэм зорилго
14	Компанийн засаглал
16	Бүтэц зохион байгуулалт
17	Удирдлагын баг
18	Хүний нөөц
20	Дэд бүтэц
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ
21	Иргэдэд хандсан бизнесийн үйл ажиллагаа
22	Байгууллагад хандсан бизнесийн үйл ажиллагаа
24	Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа
24	Худалдааны санхүүжилт ба олон улсын төлбөр тооцоо
25	Нөөцийн болон арилжааны үйл ажиллагаа
26	САНХҮҮГИЙН ҮР ДҮН
30	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ
41	НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ
42	БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ
44	БАНКНЫ САЛБАР НЭГЖҮҮДИЙН ХАЯГ
48	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
49	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД



Д.Баясгалан

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм хүндэт хувь нийлүүлэгч, харилцагч, түнш
байгууллагууд, ажиглагсад аа**

Та бүхэнд банкныхаа 2009 оны үйл ажиллагааны үр дүнг тайлагнан танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрсөн он эдийн засгийн уналт даамжран хоёр дахь Их Хямрал болон ужгирах айдас түгшүүртэйгээр эхэлж, аж үйлдвэржсэн болон шинэхэн төлөвшиж буй зах зээлийн эдийн засагтай улс орнууд эдийн засгаа өргөн хүрээнд дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг сэргэх нааштай чиг хандлагатайгаар өндөрлөсөн билээ.

Экспортод чиглэсэн эдийн засагтай улс учир эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ (ялангуяа зэсийн үнэ 70 хувиар унасан) болон экспортын хэмжээ эрчтэй буурснаас болж оны эхний саруудад манай орны эдийн засгийн өсөлт нилээд удаашралтай байлаа. Энэхүү нөхцөл байдал нь гадаад валютын нөөц, мөнгөний нийлүүлэлт болон төгрөгийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж, улмаар оны эхний улиралд бизнесийн үйл ажиллагаа хумигдахад хүрсэн билээ.

Хэдий тийм боловч, дэлхийн томоохон эдийн засагт гарч буй нааштай хандлагуудтай зэрэгцсэн Олон Улсын Валютын сантай тохиролцон хэрэгжүүлж буй Стэнд-бай (Stand-by) хөтөлбөрийн хүрээн дэх макро эдийн засгийн бодлогын үр дүн, эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн сэргэлтийн ачаар оны хоёрдугаар улирлаас эдийн засаг дахь итгэлийн түвшин нэмэгдэж, төгрөгийн ханш унах хандлагыг зогсоож чадсан юм.

БНХАУ-ын өндөр эрэлтээс үүдэлтэйгээр эрдэс баялгийн үнэ сэргэж, экспортын хэмжээ нэмэгдсэн таатай хүчин зүйлсийн үр нөлөөгөөр оны сүүлийн хагаст урсгал данс болон төлбөрийн тэнцэл сайжирч, гадаад валютын нөөц 100 хувь нэмэгдэж, улмаар төсвийн алдагдлыг бууруулж, банкны систем дэх хувийн салбарын татан



төвлөрүүлсэн хөрөнгө үлэмж өссөн юм.

Ийнхүү өнгөрсөн жилийн эхний саруудад нилээд хүнд сорилтууд тулгарсан боловч Голомт банк 14 дэх жилээ урьдын адил өндөр ашигтайгаар үдсэнийг дуулгахад таатай байна.

Татварын дараах ашиг 2008 онд 12.2 тэрбум төгрөг байсан бол өнгөрсөн онд 8 хувиар өсч 13.2 тэрбум төгрөг (9.1 сая ам.доллар)-т хүрч, нийт актив 45 хувиар өсч нэг их наяд төгрөгийн босго давлаа.

Хүүгийн орлого болон үйлчилгээний шимтгэлийн орлогыг нэмэгдүүлж, зардлын менежментийг сайжруулж, зардал орлогын харьцааг 44.9 хувьд хүргэх замаар үйл ажиллагааны ашгийг дээд хэмжээнд буюу 37.3 тэрбум төгрөг (25.8 сая ам.доллар)-т хүргэв. Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд тогтмол үрашигтай байж цэвэрхүүгийн ахиуц 4.1 хувьд, өөрийн хөрөнгийн өгөөж 22.5 хувьд, нийт өөрийн хөрөнгө 78.5 тэрбум төгрөг (54 сая ам.доллар) –т тус тус хүрсэн бөгөөд нийт өөрийн хөрөнгийн 80 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эзэлж байна.

Тайлан тэнцэлд үлэмж өсөлт гарч, нийт актив 697.2 тэрбум төгрөгөөс 1,013.1 тэрбум төгрөг (702.2 сая ам.доллар)-т, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр 57.4 хувиар өсч 505.2 тэрбум төгрөгөөс 795.3 тэрбум төгрөг (551 сая ам.доллар)-т, нийт зээл 60.3 тэрбум төгрөгөөр өсч 523.3 тэрбум төгрөг (362.7 сая ам.доллар)-т тус тус хүрчээ. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд ч сайн үр дүнтэй байсан ба зээл/татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн харьцааг 63.5 хувьд хадгалж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг 13.4 хувьд барьсан нь Төв банкнаас заасан 12 хувийн шаардлагыг хангалттай биелүүлсэн үзүүлэлт юм. Үүнтэй нэгэн адил төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт ч мөн сайн байгаа төдийгүй 51.7 хувьтай байна. Банкны зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагаандаа сахидаг хатуу шаардлага, хяналтын үр дүнд чанаргүй зээлийн хэмжээ 3.9 хувиас багахан хувиар өсч 4.4 хувь болсон бөгөөд энэ нь нийт системийн дундаж үзүүлэлтээс хоёр дахин бага байгаа юм. Жилийн эцэс гэхэд манай банкинд Монгол Улсын банкны системийн нийт өөрийн хөрөнгийн 34 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 26 хувь, нийт зээлийн 21 хувь тус тус ноогдож байна.

Голомт банк 1995 оны 3 сард Монгол Улсын анхны хувийн хэвшлийн банк болж үүсгэн байгуулагдсан билээ. Үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Банк нь 100 хувь үндэсний хөрөнгө оруулалттай банк байгаа бөгөөд хөрөнгө оруулагч Бодь групп нь дэлхийн нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран стратегийн түншлэл байгуулах замаар банкны өөрийн хөрөнгийн суурийг бэхжүүлж байна.

Банк нь Монгол Улсын банк санхүүгийн салбарт үргэлж тэргүүлэгч байж ирсэн ба картын болон олон

улсын төлбөр тооцооны зах зээлийн 60 хувийг дангаар эзэлж, гадаад худалдааны санхүүжилтын 50 хувийг гүйцэтгэж байгаа бөгөөд гадаад валютын гүйлгээний 40 хувь нь манай банкаар дамжин хийгдэж байна. Голомт банкны өрсөлдөгчөөсөө ялгарах эдгээр ололт амжилтууд, санхүүгийн болон бусад үзүүлэлтийг харгалзан үзэж, дэлхийн хамгийн нэр хүнд бүхий The Banker сэтгүүлээс Голомт банкиг 2009 оны “Монгол Улсын Шилдэг Банк”-аар тодруулсан юм.

Энэ завшааныг ашиглаад юуны өмнө манай банкны эрхэм үйлчлүүлэгч, хамтран ажиллагч банкуудад, бидэнд итгэл хүлээлгэн, хамтран ажиллаж байгаад нь талархал илэрхийлье. Мөн манай банкинд итгэж харилцдаг бүх иргэд, компаниуд, байгууллагуудад талархал илэрхийлж байна. Цаашлаад, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын төлөө ажиллаж байдаг Сангийн яам, Монголбанкны удирдлага, ажилтнуудад баярлалаа. Банкны амжилт ололтод хамтран зүтгэгч нийт 900 орчим ажиллагсаддаа талархахын ялдамд бидний ажилд үргэлж тусалж, сорилт ихтэй хүнд жилийг ийнхүү амжилттай даван туулахад зөвлөж ажилладаг хувь нийлүүлэгч Бодь Интернэшнл ХХК-д талархлаа илэрхийлье.

Дэлхийд хамгийн томдоо орох зэсийн олборлогдоогүй ордыг ашиглах талаар Оюу Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг амжилттай баталснаар 2010 он болон ирж буй он жилүүдэд манай орны эдийн засгийн төлөв байдалд үлэмж нааштай хандлага гарах боломжтой болж байна. Мөн түүнчлэн, Засгийн Газраас Таван Толгойн нүүрсний ордыг ашиглах төслийг боловсруулж дуусаад байна. Үүнээс гадна эвслийн Засгийн Газраас авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдийн үр дүнд манай үндэсний эдийн засаг улам дээшилж, үсрэнгүй хөгжлийн шатанд орох нь дамжиггүй гэдэгт итгэлтэй байна.

Туулж ирсэн 15 жилийн туршлага, түүхэн ололт амжилт дээрээ тулгуурлан Голомт банк улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, хүн ардын амьжиргааны түвшинг сайжруулахад төр засаг, байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүс, гадаадын хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч банкуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг санал болгон, улс орны цаашдын хөгжилд хувь нэмрээ оруулж, эх орон, харилцагчиддаа өөрийн мэдлэг, чадлын хирээр үйлчлэхэд бэлэн байх болно.

Д. Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга



Жон П. Финиган

Гүйцэтгэх захирал

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм хүндэт харилцагч, түнш, хувь нийлүүлэгч,
хамтран ажиллагсад аа**

Урьд өмнө тохиож байгаагүй нүргээн савалгаа, Монголын эдийн засаг, бизнес санхүүгийн орчинд өрнөсөн 2009 оны үйл явцыг нэгтгэн эргэн харахад спортын тэмцээний хоёр үетэй адилгаж болохуйц жил болж өнгөрлөө.

Дэлхийн эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн хувьд 2009 он бол хөрөнгө оруулагчдын итгэл алдах, хөрөнгө бэнчин үнэгүйдэх зэрэг нүргээн савалгаантай жил байв. Бүр оны эхний улиралд түүхэн доод хэмжээнд хүртэл унав. Өмнө тулгарч байгаагүй олон сорил бэршлээд нь мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах, хөрвөх чадварыг дэмжих бодлого зэрэг уламжлалт бус бодлогын хариу шийдвэрүүдийг шат дараатай авч хэрэгжүүлэхэд хүргэж байв. Үрэлгэн хэрэглээг дэмжсэн мөнгөний бодлого, түүний эдийн засагт үзүүлэх нөлөө, урт хугацаанд үүсэх үр дагаврыг шийдвэрлэх асуудал өнөөгийн эдийн засагт нэн тулгамдаж байгаа нь өнөөг хүртэл нийтээр даган мөрдөж ирсэн өөрийгөө зохицуулагч, үр ашигтай зах зээл буюу рационал хүлээлтэд тулгуурлсан сонгодог эдийн засгийн онолын дутуу, сул талыг нөхсөн уламжлалт бус, шинэлэг хандлагатай өвөрмөц шийдлүүд шаардлагатай байгаа юм.

Хэдий тийм боловч энэхүү гал унтраах богино хугацааны арга хэмжээнүүд нь бараг л бүх итгэл найдварыг үгүй хийсэн, зах зээлд аюул занал учруулж байсан бэрхшээлтэй байдлыг амжилттай үлдэн хөөнө гэдгийг үгүйсгэж болохгүй юм. Иймэрхүү тоо хэмжээний тайвшрал бий болгож, түлхэц бодлогууд хэрэгжүүлсний үр дүнд сөрөг мэдрэмжийг өөрчилж, Азийн эдийн засгийн хувьд олон улсын худалдаа сэргэснээр түүхий эд, хөрөнгийн үнийг сэргээж, дэлхийн эдийн засагт дахин сэргэлт авчирсан.



Монгол Улсын хувьд, долоон жил дараалан хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх эдийн засгийн өсөлттэй байсны дараа буюу 2008 оны эцсээр нээлттэй экспортод тулгуурласан эдийн засагт хүчтэйгээр нөлөө үзүүлж эхэлсэн дэлхийн санхүүгийн хямралын нөлөөнд автаж, эдийн засгийн өсөлт нь огцом унасан. Түүний дараахан, оны эхний улиралд банкны дампуурал, банкны систем дэх хадгаламжийн бууралт, инфляцийн өндөр түвшин, экспортын үнийн өсөлт, бууралтын савалгаа, гадаад валютын албан нөөцийн бууралт төдийгүй улс орон даяар болсон хатуу ширүүн өвлийн цаг агаарын бэрхшээл зэрэг маш олон үйл явдал тохиосон бөгөөд энэ бүгд бүхэлдээ бизнесийн итгэл, бүтээмжид дарамт учруулсан юм.

Мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлэх, төсөв санхүүгийн хувьд хатуу чанга шаардлагатай Олон Улсын Валютын Сангийн Стэнд-бай (Stand-by) хөтөлбөрийг зүй ёсоор нь нэвтрүүлэх зэргээр суурь арга хэмжээнүүдийг авсан билээ. Эдгээр дотооддоо авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дэлхийн эдийн засагт гарсан хамгийн чухал эерэг үзүүлэлт болох түүхий эдийн үнийн сэргэлт ихээхэн нэмэр болсон юм. Улмаар итгэлцэл сэргэж, экспортын хэмжээ өссөн (гэвч экспортын үнийн дүнгийн хувьд ихээхэн удаашралтай), валютын ханшийн тогтвортой байдал бий болсон, хавар зуны улирлын цаг агаарын таатай байдлын нөлөөгөөр банкны систем дэх хадгаламжийн өсөлт сайжирсан зэргээр уруудаж байсан үзүүлэлтүүдэд үр ашигтай өөрчлөлтүүд бий болж эхэлсэн.

Үндэсний эдийн засгийн нааштай төлөв байдлыг жилийн тайлангийн Эдийн засгийн тойм бүлгээс дэлгэрэнгүй харах боломжтой. Тайлант онд экспортын хэмжээ 25 хувиар буурсан бол экспортын үнийн дүнгийн хувьд 1,903 тэрбум ам.доллар болж буурчээ. Боловсруулаагүй газрын тосны экспорт (Монгол Улс нефть экспортлогч орон болсон учир) 81 хувь, нүүрсний экспорт 70 хувь, төмрийн хүдэр 56 хувиар тус тус өссөн нь гол амжилт байлаа. Импорт 2,131 тэрбум ам.доллар болж огцом буурсан нь 2008 онд 710 сая ам.доллар байсан худалдааны тэнцлийг 2009 онд 228.7 сая ам.доллар болгожээ.

Энэхүү гадаад худалдаанд гарсан эерэг өөрчлөлтүүд нь ДНБ-ийг нэрлэсэн үнээр 0.6 хувиар өсгөсөн боловч жилийн турш дахь ам.доллартай харилцах төгрөгийн ханш 13.8 хувь буурснаас ДНБ нь бодит үнээр 1.6 хувиар

буурсан. Эцсийн хэрэглээ, нийт хөрөнгийн бүрдэлт 70 болон 35 хувиар тус тус буурсан. 227.8 сая ам.долларын төсвийн алдагдал нь ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэж байна. Мөн тайлант онд инфляцийн түвшин амжилттай буурч, жилийн дүнгээр 4.2 хувьтай байлаа.

Оны сүүлийн саруудад бий болсон эдгээр тааламжтай нөхцөл байдал дээр тулгуурлан Голомт банк нийт активаа 45 хувиар өсгөж их наядыг даван 1,013 тэрбум төгрөг (702 сая ам.доллар)-т, татан төвлөрүүлсэн хөрөнгөө 57 хувиар өсгөж 795 тэрбум төгрөг (551 сая ам.доллар)-т, нийт зээлээ 13 хувиар өсгөж 505 тэрбум төгрөг (350 сая ам.доллар)-т хүргэсэн өндөр амжилт бүхий дахин нэг жилийг үдлээ.

Доллар, юаньтай харьцах төгрөгийн ханшийн уналт нь төгрөгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн үзүүлэлтэд өсөлтийг авчирсан. Энэхүү төгрөгийн ханшийн уналтын нөлөөг хасаж тооцвол нийт активийн өсөлт 36 хувь, татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт 36 хувь, нийт зээлийн өсөлт 7 хувьтай тэнцэж байна. Банкны системийн нийт активийн өсөлт 21 хувь, хадгаламжийн өсөлт 29 хувь, нийт зээлийн бууралт 7 хувь байгаатай харьцуулахад банкны эдгээр үзүүлэлтүүдийн абсолют өсөлтийн хэмжээ нь 45, 57, 13 хувь байгаа нь үнэхээр тэмдэглүүштэй явдал юм. Голомт банк тайлант онд болсон хүнд хэцүү сорилтыг үл харгалзан банкны харилцагчдынхаа эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг хангах, үйл ажиллагааг нь тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг болохын тулд зээлийн үйл ажиллагаагаа нээлттэй байлгасан Монгол Улс дахь цорын ганц банк байлаа.

Нийт өөрийн хөрөнгө 78.5 тэрбум төгрөг (54.4 сая ам.доллар) хүртэл өссөн ба үүний 80 гаруй хувь нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө байна. Чанаргүй зээлийн хэмжээ 6.7 тэрбум төгрөгөөр өсч 22.9 тэрбум төгрөгт хүрсэн ба хувь хэмжээгээр тооцвол 2008 оны эцэст 3.9 хувиас бага зэрэг өсч тайлант оны эцэст 4.4 хувьд хүрчээ.

Ашигт ажиллагааны хувьд бид оны эхний хагаст санхүүгийн хүчирхэг байдлаа хадгалж үлдэхийн тулд өсөлтөөс зайлсхийж, харин оны хоёрдугаар хагаст нийт актив болон ашигт ажиллагааны өсөлтийн үзүүлэлтийг тэнцвэртэй байлгах бодлого баримталсан. Үүний үр дүнд 14 дэх жилдээ ашиг өсөлттэй гарч 13.2 тэрбум төгрөг (9.13 сая ам.доллар)-т хүрсэн бөгөөд нийт активын



өгөөж 1.6 хувь, нийт өөрийн хөрөнгийн өгөөж 22.5 хувьд хүрсэн амжилттай ажиллалаа.

2008 оны 4 сараас эхлэн хоёрдугаар улирлын эцэс хүртэл хязгаарлагдаж ирсэн банкны систем дэх татан төвлөрүүлсэн хөрөнгийг хангахаар оны эхний саруудад цэвэр хүүгийн ахиуц багассан боловч хэмжээний өсөлт, уян хатан үнийн таатай нөхцөл нь эргээд нөхцөл байдлыг таатай болгож, өндөр өртөг бүхий татан төвлөрүүлсэн хөрөнгийн зардлаа нөхөхүйцээр буюу 18 хувийн хүүгийн орлогын өсөлттэй, хэдийгээр абсолют дүнгээр 7 хувиар буурсан ч оны турш тогтмол үр ашигтай байсан үзүүлэлт болох цэвэр хүүгийн орлого 4.1 хувь гарахад нөлөөлж чадсан.

Шимтгэл хураамжийн орлого 24 хувиар өсч 10.6 тэрбум төгрөг (7.34 сая ам.доллар)-т хүрсэн ба энэхүү өсөлтийн дийлэнх нь гуйвуулгын орлого болон зээлтэй холбоотой шимтгэл хураамжийн орлогын өсөлттэй холбоотой байна. Валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх стратегийг амжилттай хэрэгжүүлсэн, гадаад валютын гүйлгээний хэмжээний өсөлт зэргээс үүдэлтэй бусад үйл ажиллагааны орлого бараг 3 дахин өссөн.

Зардлын сайн хяналтыг хэвээр үргэлжлүүлсэн ба цалингийн зардал болон урамшууллын зардлын өсөлттэй уялдаатай үйл ажиллагааны зардал 10 хувиар өссөн. Зардал орлогын харьцаа 43.8 хувиас бага зэрэг өсч 44.9 хувь боллоо.

Үр ашиг бүхий, тодорхой арга хэмжээ авч ажиллаж байсан хэрэглээний зээлийн огцом бөгөөд гэнэтийн өсөлтийг хамгаалахуйцаар зээлийн алдагдлын зардлыг бууруулсан.

Голомт банк нь Монгол Улсад олон улсын санхүүгийн шинэ үйлчилгээнүүдийг анхлан нэвтрүүлэгч гэдгээрээ олонд танигдсан билээ. 2009 онд бид Монгол Улсад олон улсын төлбөрийн картын систем нэвтрүүлсний 10 жилийн ойгоо тэмдэглэсэн. Тайлант онд Голомт банк салбартаа анхдагч байр сууриа хадгалсан олон санаачлагуудыг нэвтрүүлснээс заримыг нь дурьдвал:

- Монгол Улсад хамгийн сүүлийн үеийн банкны систем гэж үнэлэгдэж буй Грэйпбанк 3 шинэ системийг амжилттай нэвтрүүлсэн;
- Аялал жуулчлал, агаарын тээврийн салбарт зориулан Олон Улсын Агаарын Тээврийн Холбооны төлбөр тооцооны системийг амжилттай нэвтрүүлсэн;

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх туршлага эзэмшсэн солонгос банкираар удирдуулсан Солонгосын бизнесийн нэгжийг шинээр амжилттай байгуулсан;
- Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагааг эхлүүлсэн;
- Интернэт банк болон мобайл банкаар үйлчилгээ хүргэх боломжуудаа шинэчлэн сайжруулсан;
- Шинээр 4 нэгжийг амжилттай нээсэн (2010 оны эхний улирал гэхэд 3 салбар нээгээд байна) ;
- АТМ-ийн салбар сүлжээгээ 2 дахин нэмэгдүүлсэн;
- Анхны хосолсон валют бүхий картыг нэвтрүүлсэн;
- Paypass картыг нэвтрүүлсэн;
- China UnionPay юаний картыг дэлхийн зах зээлд анх удаа нэвтрүүлсэн;
- Ажилчиддаа зориулсан гадаад болон дотоод мэргэжлийн сургалтыг нэмэгдүүлсэн;
- Банкны тухай шинэ хуулийн дагуу Компанийн засаглалаа сайжруулсан зэрэг болно.

Бид бүхэн эх орон болсон Монгол Улсынхаа нутаг дэвсгэрт буй харилцагчид, ирээдүйн үйлчлүүлэгчдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах шинэ боломжийг нээхийн тулд өөрийн систем, бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээний сувгаа байнга сайжруулсаар байх болно.

Голомт банк дэлхийд нэр хүнд бүхий The Banker сэтгүүлээс “Монгол Улсын Шилдэг Банк”, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас “Шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага” шагналыг хоёр дахь жилдээ, уламжлалт шагнал болсон “Топ банк” шагналыг 2009 онд Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас дахин хүртлээ. Нэмж хэлэхэд, 2010 оны эхээр банкны салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж буй манай 10 ажилтны гавъяа зүтгэлийг төр засгаас үнэлж, төрийн одон медалиар шагнав. Мөн Төв банк болох Монголбанкнаас нийт 38 ажилтныг банкны салбар дахь шилдэг ажилтнаар шалгаруулан шагнал гардууллаа.

2010 оны бизнесийн хэтийн төлөвөөс дүгнэж үзэхэд Голомт банк дараа дараагийн жилүүдэд улам итгэлтэй ирээдүйтэйгээр ажиллахаар байна. Бид өнгөрсөн арван жилд тулгарсан хамгийн хэцүү сорилтуудыг амжилттай даван туулж, хүч чадалтай, уян хатан, эрүүл гэдгээ бататгаж чадсан.



- Өндөр хөрвөх чадвар;
- Хангалтай хөрөнгө;
- Эрсдэлийн удирдлагын сайн менежмент;
- Байгууллагын зардлын эмх журамтай байдал;

гэсэн бизнесийн үндсэн зарчмаа баримтлан ажиллах болно. Голомт банк өндөр хөрвөх чадвар болон эрсдэлийн удирдлага, зардлын сайн хяналтын үр дүнд бий болсон хөрөнгийн чадавхиа хадгалсаар байна. Бид дэлхийд тэргүүлэгч байгууллага болох Кредит Свисстэй нягт хамтран ажиллаж буй одоогийн түвшинтэй эн зэрэгцэхүйц байдлаар ижил түвшний олон улсын тэргүүлэх байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх бодлого баримтлах болно. Ингэснээр богино хугацаанд зээл олгох хууль ёсны эрхийн хэмжээгээ өөрсдийн олон улсын болон дотоодын харилцагчдын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангахуйцаар өсгөж чадна. Өсөн нэмэгдсэн хөрөнгийн суурь нь бидний тогтвортой ашгийг цаашид нэмэгдүүлж, улмаар эрхэм харилцагчиддаа банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг хамгийн бага боломжит зардлаар, хамгийн ашигтай аргаар хүргэх бололцоог олгох юм. Дэлхийд тэргүүлэгч Персийн булангийн орнуудын Үндэсний хөгжлийн сан (Gulf Co-operation Council Sovereign Wealth Fund)-тай байгуулах гэж буй нь бидний өөрийн хөрөнгийн суурийг 60 гаруй хувиар эрчимтэй өсгөж чадахуйц хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хөрвөх зээллэгийн баримт бичгийг эцэслэн дуусгах шатандаа явж байгааг жилийн тайландаа дурьдахад таатай байна.

Хашир туршлага бүхий банкируудын хувьд гол төсөөлөл авах цорын ганц эх үүсвэр учраас бид дэлхийн макро эдийн засгийн хэтийн төлөвийг байнга судлан ажигладаг. Дэлхийн эдийн засагт гарч буй нөлөөллүүдийг богино хугацаанд мэдрэмжтэйгээр тусган авч эерэг өөрчлөлт бий болгох боломжийг бид урьдчилан харж байдаг. Дэлхийн эдийн засгийн өсөлт нь хэрэглээний хязгаарлалт, зээлийн хумигдалт, төсвийн хумилт зэргээс хамаарч өмнөх жилүүдийнхтэй адил өндөр байсангүй. Гэсэн ч Хятад Улс болон түүний хурдацтай өсөн хөгжиж буй эдийн засгаас улбаатай Азийн өөрчлөлт хөгжлийн нэгдэл нь Монгол Улсад сайнаар нөлөөлсөөр байна гэдэгт бид итгэл дүүрэн байна. Тиймээс манай улсын болон Банкны ирээдүй аль аль нь шилжилт, өөрчлөлт рүү дээшилсээр байх болно.

Бид цаашдын хэтийн төлөв байдлаа төсөөлөхдөө зөвхөн гадаад орчны таатай нөхцөл байдлыг тусгаагүй Засгийн Газрын Рио Тинто болон Айвенхоу Майнз компаниудтай хамтран хэрэгжүүлж буй Өмнөговь аймаг дахь Оюу Толгой ордыг ашиглах, хөгжүүлэхэд эрчимтэй анхаарсан Хөрөнгө Оруулалтын гэрээний амжилттай үр дагаварыг мөн бодож үзсэн юм. Одоогийн зах зээлийн ханшаар 341 тэрбум ам.долларын үнэ цэнэтэй, мөн эхний шатандаа 5 тэрбум ам.долларын (одоогийн ДНБ-ээс их) нийт хөрөнгийн зардлыг хангах 39 сая тонн зэс болон 58 сая унц алтны батлагдсан нөөцтэй уг ордыг ашиглах төсөл нь хөгжлийн үе шатны туршид (дотоодын зардлыг нэмэгдүүлэх хэд хэдэн нөлөөгөөр) үндэсний эдийн засагт өөрчлөлт хувьслыг авчирч, 2013 оноос хойш экспортын орлогын урсгал бий болж эхэлнэ.

Үүнтэй төсөөтэйгээр 6.3 тэрбум гаруй тонн батлагдсан нөөцтэй, одоогийн зах зээлийн ханш нь 1 триллион гаруй ам.долларын үнэтэй, мөн 2.5 тэрбум ам.долларын хөрөнгийн зардалтай Таван Толгойн нүүрсний орд нь ойрын жилүүдэд эдийн засгийн өсөлтөд эрчимтэй хувь нэмэр оруулах болно. Эдгээр олборлох аж үйлдвэрийн гол төслүүдээс гадна уран, газрын тосны нөөцийн үр ашигтай бөгөөд хүрээлэн буй орчны хувьд мэдрэмжтэй ашиглалтаас ашиг олох, мөн түүнчлэн зам, төмөр зам, түлш эрчим хүчний үйлдвэрлэл болон орон сууц, боловсролын болон эмнэлгийн байгууламжийн төслүүдээс үр ашиг хүртэх болно.

Монгол Улс нь өнөөдрийг хүртэл тун бахархмаар өв уламжлалтай, гэрэлтсэн сайхан ирээдүйтэй орон байсаар ирсэн. Голомт банкинд ажиллаж байгаа бид бүхэн улсынхаа эдийн засгийн өсөлт болон иргэдийнхээ өсөн нэмэгдэж буй хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, тэдгээр хүсэл тэмүүллийн биелэлтэд хүрэх бүхий л боломжит арга замд хувь нэмрээ оруулахын тулд та бүхэнд үйлчлэх болно.

Жон П.Финиган
Гүйцэтгэх Захирал



ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА ГАДААД ХУДАЛДАА

Тайлант 2009 онд Монгол Улсын ДНБ-д гарсан өөрчлөлтийн тухайд, оны эхний хагаст экспортын хэмжээний бууралттай холбоотойгоор үйлдвэрлэлд огцом уналт бий болж, харин оны сүүлийн хагаст орлогын хэмжээ бага зэрэг өсөлттэй гарлаа. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд дунджаар 8.62 хувийн өсөлттэй байсан Монголын эдийн засаг 2009 онд барилга, худалдаа, зочид буудал, санхүүгийн салбаруудаас шалтгаалж бууралттай гарав.


ДНБ-ий 45 хувийг эзэлсэн экспортын хэмжээ алтнаас бусад үндсэн төрлүүд дээр хэвийн өсөлттэй байлаа. Экспортын орлогын хэмжээ өмнөх 2008 оноос 25 хувиар буурч 1.9 тэрбум ам.долларт хүрэв. Экспортын хэмжээ нь зэсийн баяжмалын хувьд харьцангуй тогтмол өсөлттэй байсан буюу жилийн туршид гарсан өсөлт нь 1 хувьтай тэнцүү байна. Харин Хятад Улсын түүхий эдийн эрэлт өссөнтэй холбоотой түүхий нефть, нүүрс, молибден, төмрийн хүдэр, цайр тус бүр 81, 70, 66, 56, 10 хувиар өсчээ.

Лондонгийн Металлын Бирж дээрх зэсийн үнэ нь мэдэгдэхүйц буюу 140 хувиар өссөний улмаас Хятад Улсын зэсийн импортын эрэлт хэрэгцээ 119 хувиар өссөн. Алтны үнийн хувьд жилийн турш тогтвортой байдлаа хадгалж (дунджаар нэг унц нь 972 ам.доллар орчим) ирсэн ба алт олборлолтын салбар бас нэгэн таатай жилийг үдлээ. Боловсруулаагүй ноолуурын экспорт 85 хувиар, боловсруулж самнасан ноолуурын экспорт 2 хувиар өслөө.


Импортын хэмжээ болон үнийн дүн аль аль нь урьдчилан таамаглаж байсны дагуу буурсан бөгөөд энэхүү бууралтад нэгдүгээрт, бензин, дизель түлшний үнийн бууралтын таатай нөлөө, хоёрдугаарт оны эхний сарууд дахь мөнгөний ханшийн уналт, бизнесийн үйл ажиллагаа огцом буурснаас үүдэлтэй импортын зарим нэрийн бараа бүтээгдэхүүний тухайлбал барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизмийн импортын эрэлт хэрэгцээний бууралт нөлөөлжээ. Импортын хэмжээ 2008 оны эцэст 3.25 тэрбум ам.доллар байснаас 35 хувиар буурч 2.13 тэрбум ам.долларт хүрснээр 2008 онд 710 сая ам.доллар байсан гадаад худалдааны алдагдлыг 229 сая ам.доллар болтол огцом бууруулжээ. Гэсэн хэдий ч гадаад худалдааны тоо мэдээллийг харвал бууралтын 14 хувь нь жилийн туршид үргэлжилсэн гадаад валюттай харилцах төгрөгийн ханшийн сулралтаас үүдэлтэй ажээ.

Дээрх нөхцөл байдлын үр дүнд дотоодын үйлдвэрлэлийн 20 хувийн өсөлт нь нэрлэсэн дүнгээр ДНБ-ийг 0.6 хувиар өсгөж 6.055 их наяд төгрөгт хүргэсэн боловч ДНБ нь бодит үнээрээ оны эхний саруудад түүхий эд материалын үнээс хамаарч огцом бууна гэж таамаглаж байсантай харьцуулахад харьцангуй зөөлнөөр буюу 1.6 хувиар буурсан байна. 2008 онд Монгол Улсын нийт хүн ам 2.684 сая байснаас 1.9 хувиар өсч 2009 оны эцэст нийт хүн амын тоо 2.737 сая болов. Хүн амын өсөлт нь ДНБ-ий өсөлтийг бий болгодог ч нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1,819 ам.доллараас 1,532 ам.доллар болж буурлаа. Энэхүү үзүүлэлтийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлбэл тогтмол байсан байна.

ДНБ-ий бодит өсөлт (%)



Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ (ам.доллар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



2010 оны хувьд дэлхийн зах зээл дээр тогтворжиж буй түүхий эдийн үнэ болон уул уурхайн салбарт хийгдэж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхтэй холбоотойгоор эдийн засаг огцом өснө гэсэн хүлээлттэй байна. Уул уурхайн салбарыг бүхэлд нь хамарсан томоохон эргэлт болж, олны анхаарал татсан хоёр чухал үйл явдал өрнөлөө. Үүний нэг нь эдийн засагт ирэх 2.5 жилийн дотор 4 тэрбум ам.доллар оруулж ирэх, 2013 оноос эхлэн үйлдвэрлэл явуулж эхлэн, жилдээ 7.5 тэрбум ам.долларын экспортын орлого авчрах Оюутолгойн орд газрыг ашиглах тогтвортой байдлын гэрээг Монгол Улсын Засгийн газар Айвенхоу Майнз Инк Монголиа ХХК болон Рио Тинто групптэй байгуулсан явдал юм. Үүнээс гадна 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө шаардлагатай гэж тооцоологдож, жилд 8 тэрбум ам.долларын орлого авчрахаар хүлээгдэж буй Таван толгойн нүүрсний орд газрыг эргэлтэнд оруулах төслийн баримт бичгийг эцэслэн боловсруулж дуусч байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2005	2006	2007	2008	2009
Хүн ам (000)	2,562	2,595	2,635	2,684	2,737
Хүн амын өсөлт (%)	1.2	1.2	1.5	1.8	1.9
ДНБ (сая ам.доллар)	2,067	3,189	3,931	4,837	4,197
ДНБ-ий өсөлт (%)	7.3	8.6	10.2	8.9	-1.6
1 хүнд ноогдох ДНБ (ам.доллар)	894	1,237	1,490	1,819	1,532
Инфляци (%)	11.6	6	18	22	4
Ам.долларын ханш (оны эцэст)	1,221	1,165	1,170	1,268	1,443
Экспорт (сая ам.доллар)	1,054	1,543	1,948	2,535	1,903
Худалдааны тэнцэл (сая ам.доллар)	-95	107	-114	-710	-229
Банкуудын тоо	17	16	16	16	15
Банкны нөөц (сая ам.доллар)	868	1,992	2,892	2,880	3,065
Зээл/ДНБ (%)	33	33	47	44	44
Чанаргүй зээл (%)	6	5	3	7	17

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ДНБ-ий бүтэц

	2005	2006	2007	2008	2009
ДНБ, нэрлэсэн үнээр (тэрбум.төг)	2,524.3	3,172.4	4,599.5	6,019.8	6,055.8
ДНБ өсөлт, бодит үнээр	7.10%	8.60%	10.20%	8.90%	-1.60%
Нэг хүнд ноогдох ДНБ (мян.төг)	893.5	1,236.70	1,745.44	2,243.26	2,213.73
ДНБ-ий өсөлт салбараар:					
Хөдөө аж ахуй	9.60%	7.50%	15.80%	5.80%	1.50%
Уул уурхай, олборлолт	19.90%	6.30%	2.90%	-2.90%	3.70%
Үйлдвэрлэл	10.90%	13.40%	29.00%	3.80%	-11.10%
Цахилгаан, хий & ус нийлүүлэлт	-17.40%	4.50%	7.50%	9.20%	3.80%
Барилга	0.80%	5.10%	8.50%	-12.80%	-48.80%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	15.40%	15.30%	6.70%	16.20%	-26.60%
Зочид буудал, ресторан	6.20%	9.90%	16.00%	6.90%	-23.00%
Тээвэр, харилцаа холбоо	17.30%	12.10%	26.60%	20.50%	12.10%
Санхүүгийн зуучлал	19.70%	-3.20%	30.20%	19.90%	-20.40%
Үл хөдлөх хөрөнгө	14.30%	5.40%	-1.70%	19.60%	2.80%
Төрийн захиргаа, батлан хамгаалах	3.80%	0.50%	4.50%	4.20%	4.20%
Боловсрол	3.40%	4.40%	2.10%	7.50%	1.70%
Эрүүл мэнд, нийгмийн салбар	-3.00%	9.30%	10.70%	5.80%	3.30%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



Монгол Улсын экспортод үндсэндээ 10 орчим нэрийн бараа бүтээгдэхүүн голох байр суурийг эзэлдэг буюу үүнээс зэсийн баяжмал, нүүрс, алт гэх мэт нийт экспортын 90 хувийг эзэлдэг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнүүд байдаг. Экспортын гол арван нэрийн бүтээгдэхүүний дотор нүүрс, газрын тос, бохир ноолуурын экспорт хоёр оронтой тоогоор буюу 12-65 хувиар өссөн бол үлдсэн долоон нэрийн бүтээгдэхүүн 2008 оны эцэстэй харьцуулахад 6-50 хувиар унасан байна. Гэсэн хэдий ч оны хоёрдугаар хагаст энэхүү 10 нэрийн бүтээгдэхүүний хэмжээнд мэдэгдэхүйц өсөлт гарсан. Тухайлбал алт болон зэсийн экспорт тогтмол байхад боловсруулаагүй газрын тос, нүүрс, молибден, төмрийн хүдэр, цайр тус тус 81, 70, 66, 56, 10 хувиар өсчээ. Оны хоёрдугаар хагаст 2008 оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй болон угаасан ноолуурын экспорт 2 болон 85 хувиар тус тус өсчээ.

Хэрэглээнд тулгуурласан эдийн засагтай орны хувьд Монгол Улс хүнсний бүтээгдэхүүнээс эхлээд машин механизм хүртэл олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортолдог. Импортын 90 хувийг 9 нэр төрлийн бүтээгдэхүүн эзэлдэг. 2009 онд нийт импорт өмнөх онтой харьцуулахад 34 хувиар буурч 2,131 сая ам.долларт хүрсэн. Импортын хэмжээ нефть болон тээврийн хэрэгслийн хувьд хамгийн ихээр буюу 41 хүртэл хувиар буурчээ. Импортын энэхүү бууралт нь төгрөгийн ханш суларсан болон бензин, дотоодын худалдан авах чадвар буурснаас шалтгаалжээ.

2009 онд гадаад худалдааны эргэлт 30 хувиар буурч 4,034 сая ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны алдагдал 68 хувиар буурч 229 сая ам.доллар болсон. Үүний үр дүнд 2009 онд ДНБ дэх гадаад худалдааны сөрөг нөлөөлөл 30 хувиар багассан байна.

Гадаад худалдаа (сая доллар)

	2007	2008	2009	'09/'07	'09/'08
Нийт экспорт	1,947	2,534	1,903	(2%)	(25%)
Зэсийн баяжмал	811	836	502	(38%)	(40%)
Алт	235	600	336	43%	(44%)
Нүүрс	116	185	305	163%	65%
Цайрын хүдэр	176	155	122	(30%)	(21%)
Боловсруулаагүй нефть	53	102	114	114%	12%
Бохир ноолуур	63	77	92	45%	19%
Төмрийн хүдэр	16	92	87	444%	(6%)
Самнасан ноолуур	114	99	68	(40%)	(31%)
Молибдений хүдэр	76	82	53	(31%)	(36%)
Жоншны хүдэр	45	59	30	(34%)	(50%)
Нийт импорт	2,062	3,245	2,131	(3%)	(34%)
Эрдэс бүтээгдэхүүн	603	964	567	(6%)	(41%)
Машин, механик төхөөрөмж	424	606	423	(0%)	(30%)
Тээврийн хэрэгсэл	223	459	269	21%	(41%)
Хүнс	159	231	182	15%	(21%)
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн	164	267	164	0%	(39%)
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	108	151	128	18%	(15%)
Мал амьтны гаралтай бүтээгдэхүүн	79	160	98	23%	(39%)
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	67	84	66	(2%)	(21%)
Чулуу, гөлтгөнө, цемент	47	66	52	11%	(21%)
Гадаад худалдааны эргэлт	4,009	5,779	4,034	1%	(30%)
Гадаад худалдааны тэнцэл	(114)	(710)	(229)	(100%)	68%



Нийт экспортын хэмжээ

	2007	2008	2009	'09/'07	'09/'08
Зэсийн баяжмал (мян.тонн)	607.8	582.9	586.9	(3%)	1%
Алт (тонн)	11.6	22.1	11.7	1%	(47%)
Нүүрс (мян.тонн)	3,269.0	4,169.3	7,087.4	117%	70%
Бохир ноолуур (тонн)	1,510.5	1,929.2	3,576.6	137%	85%
Цайрын хүдэр (мян.тонн)	132.6	137.5	150.7	14%	10%
Тос (мян.барел)	812.3	1,058.9	1,919.4	136%	81%
Төмрийн хүдэр (мян.тонн)	240.4	1,013.1	1,576.1	556%	56%
Самнасан ноолуур (тонн)	1,784.5	1,587.8	1,623.3	(9%)	2%
Молибдений хүдэр (мян.тонн)	3.2	4.1	6.8	113%	66%
Жоншны хүдэр (мян.тонн)	360.0	348.8	147.0	(59%)	(58%)

УЛСЫН ТӨСӨВ

Хүндрэл бэрхшээл хэдий их байсан ч Монгол Улсын Засгийн Газар хувийн хэвшлийн салбарын уналтын түвшинг сааруулах зорилгоор одоогийн зардлын хэмжээг өмнөх жилийн түвшинтэй ижил байлгах аргаар төсвийн тэлэх бодлогыг баримтлан ажилласан. 2009 онд төсвийн нийт орлого 8 хувиар буурч 1,993 тэрбум төгрөгт хүрсэн ба татварын бус орлого 42 хувиар өсч, 350 тэрбум төгрөгт хүрлээ. Харин төсвийн нийт зарлага 2,322 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны түвшинтэй ойролцоо байгаа буюу 6 хувиар буурсан үзүүлэлт юм. Төсвийн нийт алдагдал 328.6 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 8 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэж байна.

Тодруулбал төсвийн зардал дахь 6 нэр төрлийн гурвынх нь хувьд дунджаар 17 хувийн бууралт гарсан бол үлдсэн гурван нэр төрөл нь дунджаар 22 хувиар өсчээ. Эдгээрээс капитал зардал, цэвэр зээлийн зардал нь 27, 18 хувиар тус тус буурсан байна. Харин төсөвт эзлэх цалингийн зардал болон шилжүүлэг татаасын зардлууд өссөн. Эдгээрээс зээлийн төлбөрийн зардал ба шилжүүлэг, татаасын зардал нь 46 хувь, 14 хувиар тус тус өссөн байна.

Улсын төсөв (тэрбум төгрөг)

	2007	2008	2009	'09/'07	'09/'08
Төсвийн нийт орлого (тэрбум төгрөг)	1,880.5	2,156.4	1,993.0	6%	(8%)
Татварын орлого	1,502.3	1,888.9	1,615.3	8%	(14%)
Татварын бус орлого	353.7	247.2	350.3	(1%)	42%
Тусламжийн орлого	22.0	15.9	24.5	0%	55%
Хөрөнгийн орлого	2.5	4.4	3.0	17%	(33%)
Төсвийн нийт зарлага	1,747.3	2,462.0	2,321.6	33%	(6%)
Бараа, үйлчилгээний зардал	672.7	1,030.7	969.5	44%	(6%)
Цалин, хөлс	296.3	543.1	578.9	95%	7%
Зээлийн үйлчилгээ төлбөр	18.6	19.8	29.0	56%	46%
Татаас ба шилжүүлэг	676.4	699.0	793.6	17%	14%
Хөрөнгийн зардал	299.5	624.9	457.9	53%	(27%)
Цэвэр зээл	80.1	87.6	71.6	(11%)	(18%)
Төсвийн тэнцэл	133.2	-305.7	-328.6	(347%)	8%



Төсвийн орлогын хувьд үзүүлэлтийн тал хувьд нь өсөлт гарсан байхад үлдсэн тал хувьд нь бууралт гарсан байна. Төсвийн орлого дахь татварын бус орлого болон тусламжийн орлого дунджаар 48 хувиар өссөн бол татварын орлого 23 хувиар буурчээ.


ИНФЛЯЦИ

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт 2008 оны 8 сард жилийн сууриараа 32 хувьд хүртэл өсөв. Үүний эсрэг Төв банкнаас амжилттай арга хэмжээ авсны үр дүнд 2009 оны сүүлчээр инфляци жилийн дүнгээр 4.2 хувь болтол буурсан. Монголбанк 14 хоногт нэг удаа валютын зах зээлд ам.доллар худалдан авах, зарах замаар гадаад валютын тогтворгүй байдлыг намжаасан бөгөөд энэ нь төгрөгийн ханш дөрөвдүгээр сараас эхлэн 1 ам.доллар нь 1425 төгрөгтэй тэнцэж тогтворжиход ихээхэн нөлөөлсөн.

Монголбанк үнийн ерөнхий түвшинд гарч байгаа өсөлтөөс хамааран хатуу мөнгөний бодлого баримталж, бодлогын хүүгээ 10.25 хувиас 14 хувь хүртэл өсгөсөн. Инфляци оны сүүлчээр буурсантай уялдуулан Монголбанк бодлогын хүүгээ 10 хувь хүртэл гурван удаа бууруулсан.

Инфляцийн түвшин (жилээр)

	2007	2008	2009
Хүнсний бараа, ундаа, ус	24.5%	24.5%	-0.5%
Согтууруулах ундаа, тамхи	-1.2%	8.8%	22.4%
Хувцас, бөс бараа, гутал	2.1%	26.1%	3.6%
Орон сууц, ус, цахилгаан, түлш	7.0%	17.3%	-3.8%
Гэр ахуйн тавилга, бараа	12.5%	14.8%	6.3%
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	18.6%	27.6%	14.2%
Тээвэр	10.7%	33.8%	-0.8%
Ерөнхий индекс (жилээр)	15.1%	22.1%	4.2%





БАНК САНХҮҮ

М2 мөнгө 27 хувь өсч 2,880 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь ДНБ-ий 48 хувьтай тэнцүү байна. Харин банкны систем дэх нийт актив 21 хувиар өсч 4.422 их наяд төгрөг (3.06 тэрбум ам.доллар) болсон бөгөөд энэ нь ДНБ-ий 73 хувьтай тэнцэж байна.

Банкны систем дэх нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 2009 онд 648 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 2.9 их наяд төгрөг (2.02 тэрбум ам.доллар)-т хүрсэн. Систем дэх нийт зээлийн хэмжээ 2008 оны эцэст байсан 2.569 их наяд төгрөгөөс 6.8 хувиар буурч 2.395 их наяд төгрөгт хүрсэн нь оны эхний хагаст банкны салбар дахь эх үүсвэр буурсантай холбоотой юм. Тайлант оны эцэс гэхэд банкны систем дэх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 41.5 болж өссөн. Банкны салбарын зээл хадгаламжийн харьцаа 113 хувь байснаас мэдэгдэхүйц сайжирч 2009 оны 12 сарын эцэст 81 хувь болсон.

Банкны системийн хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2009 оны эцэст өмнөх оноос 194 тэрбум төгрөгөөс 154 хувиар өсч 492 сая төгрөгт хүрсэн байна. Хугацаа хэтэрсэн зээл энэ хэмжээгээр нэмэгдсэний ихэнх хувь нь Төв банкнаас эрх хүлээн авах үйл ажиллагаа явуулсан (сүүлд Зоос банкныг эрх хүлээн авагч томилж Төрийн банк болгосон) хоёр банкинд оногдож байна.

2009 онд Монгол Шуудан болон Хадгаламжийн банк нэгдсэн онцлог үйл явдал банк санхүүгийн салбарт тохиолоо. Хоёр банк нэгдсэнээр банкны системийн нийт активийн 8.5 хувийг, нийт зээлийн 9.4 хувийг эзэлж байна.

Банкны системийн үндсэн үзүүлэлтүүд

	2005	2006	2007	2008	2009
Банкны тоо	17	16	16	16	15
Банкны салбаруудын тоо	731	832	981	1,080	1,044
Банкны нэг салбарт ноогдох хүн ам	3,501	3,132	2,686	2,485	2,624
Нийт актив (сая ам. доллар)	1,298	1,992	2,892	2,880	3,065
Нийт хадгаламж (сая ам. доллар)	819	1,248	1,900	1,790	2,022
Нийт зээл (сая ам. доллар)	752	1,075	1,860	2,142	1,887
1 хүнд ноогдох хадгаламж (мян.төгрөг)	270	374	575	566	719
Нийт актив, ДНБ-ий харьцаа	70.0%	62.5%	73.6%	59.5%	73.0%
Нийт зээл, ДНБ-ий харьцаа	36.8%	32.9%	47.3%	44.3%	45.0%
Нийт өөрийн хөрөнгө, ДНБ-ий харьцаа	9.1%	7.9%	8.2%	5.6%	3.8%
Чанаргүй зээл (%)	5.4%	4.7%	3.1%	7.1%	17%
Дундаж өөрийн хөрөнгийн хүрэлцээ	20.1%	19.4%	15.6%	11.9%	8.2%
Банк бус санхүүгийн байгууллагын тоо	150	163	137	132	172



БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ


ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

ХЭТИЙН ЗОРИЛГО

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн цогц үйлчилгээ үзвэлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


Голомт банк нь Компанийн засаглалын хэм хэмжээ болон олон улсад шалгарсан туршлагыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг эрмэлздэг бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкнаас гаргасан журмуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ дотооддоо дүрэм журам боловсруулан хэрэгжүүлдэг.

Энэ хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Банкны Компанийн Засаглалын Бодлогын Тунхаглал”-ыг батлан гаргасан бөгөөд үүнд банкны “Ёсзүйн код”-ыг агуулсан олон улсын Компанийн засаглалын шалгарсан туршлагыг чиглүүлэгч үндсэн зарчмууд багтаж байна.

Бид Компанийн засаглалын хэм хэмжээндээ хувь нийлүүлэгчдийн нягт харилцаа, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Аудитын Хорооны үр ашигтай хамтын ажиллагаа, үйл ажиллагааны үр дүнд тулгуурласан урамшуулал, нээлттэй ил тод байдал гэсэн үндсэн 4 зарчмыг баримталдаг.



КОМПАНИЙН ЗАСАГЛААЛЫН БҮТЭЦ



ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ

Голомт банк нь “Бодь Интернэшнл” гэсэн нэг хувь нийлүүлэгчтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувь нийлүүлэгчдээс томилогдсон банк санхүү, бизнесийн салбарт олон жил ажилласан туршлага бүхий гурван гишүүнээс бүрддэг. Зөвлөл нь Банкны төсөв, бизнесийн болон хэтийн төлөвлөгөөг батлах, удирдлагуудыг томилох, хөндлөнгийн хяналт тавих, банкны бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох зэрэгт удирдлагаар хангаж, эрсдэлд үнэлгээ өгөх замаар банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

АУДИТЫН ХОРОО

Аудитын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон Зөвлөлд ажлаа шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор хяналтын систем, зохих баримтлал, тооцооны аргуудаар санхүүгийн бүхий л асуудалд шударга, үр дүнтэй санал зөвлөмжүүдийг гаргах замаар хяналт тавин ажилладаг. Хороо нь Дотоод Аудитын Газарт хяналт тавих үүрэгтэй бөгөөд хөндлөнгийн аудиторуудтай нягт хамтран ажиллана.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО


Эрсдэлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон, үйл ажиллагаагаа Зөвлөлд шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны эрсдэлийг урьдчилан илрүүлэх зорилгоор эрсдэлийн өсөлт болон хязгаар, тоон хэмжээ, хэмжилт дээр үндэслэн зохих санал зөвлөмжийг гарган ажилладаг.

УДИРДЛАГЫН БАГ

Банк нь мэргэжлийн өндөр ур чадвар бүхий туршлагатай удирдлагын багтай бөгөөд энэ нь үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгээс тодорхой харагддаг бөгөөд тэдний зарим нь банк байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал болон Тэргүүн дэд захирал, Дэд захирал, Газрын захирал, Хэлтсийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





УДИРДЛАГЫН БАГ



Г. Ганболд
Тэргүүн дэд захирал



Г. Ганхуяг
Дэд захирал, Хөрөнгийн Удирдлагын
Газрын захирал



М. Чимэгмөнх
Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын
Газрын захирал



Н. Нацагдорж
Дэд захирал, Иргэдийн Банкны
Газрын захирал



Л. Оюун-Эрдэнэ
Дэд захирал, Байгууллагын Банкны
Газрын захирал



М. Чингүн
Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын
Газрын захирал



Б. Загал
Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын
Банкны Газрын захирал



Ж. Ганбат
Дотоод Аудитын
Газрын захирал



Д. Мөнхтөр
Бүртгэл Тооцооны
Газрын захирал



Төлөөлөн Удирдах Зөвлөл	Д. Баясгалан – Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л. Болдхуяг М. Зоригт
Аудитын Хороо	Б. Моломжамц – Дарга С. Шинэжаргал – Мэргэшсэн нягтлан бодогч Б. Тамир
Эрсдэлийн Удирлагын Хороо	Л. Болдхуяг – Дарга М. Зоригт Жон П.Финиган М. Чимэгмөнх М. Чингүн
Удирдлагын баг	Жон П.Финиган Гүйцэтгэх захирал Г. Ганболд Тэргүүн дэд захирал Г. Ганхуяг Дэд захирал, Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал М.Чимэгмөнх Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын Газрын захирал Л. Оюун-Эрдэнэ Дэд захирал, Байгууллагын Банкны Газрын захирал Н. Нацагдорж Дэд захирал, Иргэдийн Банкны Газрын захирал М.Чингүн Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын Газрын захирал Б. Загал Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын захирал Ж.Ганбат Дотоод Аудитын Газрын захирал Д. Мөнхтөр Бүртгэл Тооцооны Газрын захирал Н. Цэрэндаваа Мэдээллийн Технологийн Хэлтсийн захирал Д. Батбилэг Картын Төвийн захирал Б. Энхтуяа Маркетингийн Хэлтсийн захирал

ХҮНИЙ НӨӨЦ

Банкны ололт амжилтын үндэс суурь нь чадвартай, мэргэжлийн ур чадвар бүхий, үнэнч шударга, бүтээмж өндөртэй ажилтнууд юм. Тайлант оны туршид банкны Хүний нөөцийн бодлого ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадвар, бүтээмжийг дээшлүүлэн, сургалтад хамруулахыг гол чиглэл болгосон юм.

2009 онд нийт 111 шинэ ажилтан авч, оны эцэс гэхэд нийт ажилтнуудын тоо 867-д хүрлээ. Нийт ажилтнуудын 60 хувь нь банкны үйлчилгээг 59 салбар тооцооны төвөөр дамжуулан харилцагчдад хүргэж, 40 хувь нь төв албанд ажиллаж байна.

Хүний Нөөцийн Үндсэн Үзүүлэлтүүд

	2008	2009
Ажилтны тоо	874	867
Салбар тооцооны төвүүд	60%	60%
Төв албанд	40%	40%
Ажилтны хүйсийн харьцаа (эрэгтэй/эмэгтэй)	30-70	30-70
Салбар тооцооны төвүүд	24-76	23-77
Төв албанд	39-61	41-59
Дунд түвшний удирдлага	45-55	45-55
Дээд түвшний удирдлага	50-50	50-50
Мэргэжлийн зэрэг		
Бакалаврын зэрэг	78%	78%
Магистрийн зэрэг	10%	10%
Дунд боловсролтой	12%	12%

**Хүний Нөөцийн Үндсэн Үзүүлэлтүүд**

	2008	2009
Нас		
25 хүртэлх	34%	25%
25-34	50%	56%
35-44	12%	14%
45-54	3%	4%
54-с дээш	1%	1%

Банк нь ажиллах хүчний тоо хэмжээг өргөжүүлэхэд бус, хамт олны эгнээнд шинээр орсон болон он удаан жил ажиллаж буй нийт ажиллагсдынхаа мэдлэг, мэргэжлийн ур чадвар, үйлчилгээ үзүүлэх чадварыг сайжруулахад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх олон төрлийн сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд илүүтэй ач холбогдол өгч ажилласан.

Өнгөрөгч онд ажилтнуудын дунд ажил мэргэжлийн түвшин тогтоох үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Үүний үр дүнд ажилтнуудын албан тушаал ахих, цалингийн шатлал нэмэгдэх мөн ажлын байрыг оновчтойгоор хуваарилах ажлууд амжилттай хийгдлээ.

Тайлант онд манай 56 тэргүүний ажилтан Сангийн яам, Монголбанк, Монголын Залуучуудын Холбоо, Улаанбаатар Хотын Захирагчийн Албанаас тус тус шагнагдлаа.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

Сургалтын хөтөлбөрүүд нь мэргэжлийн болон боловсон хүчний сургалтуудыг хамардаг бөгөөд мэргэжлийн ур чадвар бүхий багш нар орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон сургалтын танхимд тасралтгүйгээр явуулж байна.

Банкны мэргэжлийн чадварлаг ажилтан бэлтгэх зорилгоор 5 удаагийн теллерийн мэргэшүүлэх сургалтаар нийт 88 ажилтныг бэлтгэн ажиллуулж байна. Мөн банкны зээлийн ажилтан болон хянагч нягтлан бодогч бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж амжилттай хэрэгжүүлээ.

Бүх шатны удирдлагууд, ахлах ажилтнуудын мэдлэг чадвар, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд удирдах ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрөө манлайлал болон нийгмийн салбар чиглэлээр тэргүүлэх байгууллагуудад амжилттай туршигдаж, батлагдсан технологиор амжилттай шинэчлэн зохион байгууллаа. Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагууд, олон улсын экспертүүдтэй хамтран ажиллаж, туршлага солилцох замаар ажилтнуудынхаа мэдлэг туршлагыг нэмэгдүүлж байна.

Тайлант онд нийт 2,119 ажилтан сургалтанд хамрагдсан ба энэ нь дунджаар нэг ажилтанд оногдох сургалтын цаг 36,4 болж, өмнөх онтой харьцуулахад 10 хувиар өссөн байна. Жилийн турш Төв алба, хөдөө орон нутгийн 11 аймгийг оролцуулан бүх ажилтан, албан хаагчиддаа зориулсан үр ашигтай сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд бүх аймгийн салбаруудад ур чадвартай мэргэжилтэн, мэргэжлийн сургагч шалгаруулж бэлтгэхэд илүү анхаарч ажиллалаа.

Сургалтын Статистик Үзүүлэлтүүд

	2008	2009
Нийт ажилтанд оногдох сургалт /цагаар/	28.9	36.4
Сургалтанд оролцогчид	1,988	2,119



ДЭД БҮТЭЦ

Үйлчилгээний чанар, үр ашиг, өртөг зардлын үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилгоор Банк нь үндсэн системээ шинэчилж, Грэйпбанк системийг амжилттай суурилууллаа. Ингэснээр бид харилцагчиддаа “бодит цаг”-ийн үйлчилгээ хүртэх өндөр боломжоор хангаж, салбар сүлжээгээрээ дамжуулан банкны үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтын систем, бүртгэл тооцоо, дотоод мэдээллийн уялдаа холбоо тайлагналтын чадавхиа сайжруулсан юм.

Банкны үндсэн системүүдийн сервер компьютер болон өгөгдлийн сангийн серверүүдийг шинэчлэн суурилуулсан нь харилцагчдын мэдээллийн нууцлалыг өндөр түвшинд хамгаалах, банкны систем мэдээллүүдийн найдвартай ажиллагаа, хадгалалт, харилцагчдад үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжийг бий болгосон.

Банкны картын систем кластер систем болон стораж серверт шилжсэнээр хэрэглэгчийн мэдээлэл найдвартай хадгалагдах, систем тасралтгүй ажиллах боломжийг олгож өгсөн. Мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг тасралтгүй хийх зорилгын хүрээнд шинээр 30 ширхэг Diebold ATM, 98 ширхэг Verifone GPRS POS терминал, 321 ширхэг LAN болон Dial-Up POS терминалыг шинээр суурилуулав.

Дотоодын банкны салбарт сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг анхлан нэвтрүүлэгч байр сууриа хадгалж, дэлхийн зах зээлд анх удаа China Unionpay юаний картыг хүлээн авах, карт гаргах төслийг болон Монгол Улсад анх удаа хосолсон валюттай карт нэвтрүүлэх төслийг амжилттай нэвтрүүллээ. Эдгээр санал санаачлага нь найдвартай аюулгүй байдлын орчин дахь интернэт банк болон банкны электрон үйлчилгээний ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлж, улмаар гүйлгээнд буй бэлэн мөнгөний үр ашиггүй хэрэглээг багасгахын төлөө ажиллаж буй нь бидний ажлын илэрхийлэл болж байна.

Харилцагчиддаа илүү хурдан шуурхай, найдвартай, ашигтай гэсэн нэмэлт үр ашиг бүхий үйлчилгээний сувгийг санал болгохын тулд электрон үйлчилгээнийхээ боломж нөхцөлийг улам өргөжүүлэн сайжруулахад анхаарал тавьж ажиллав. Тухайлбал:

- Мессэж банкны үйлчилгээгээ өргөжүүлж, дансны орлого зарлагыг мессэжээр мэдээлэх үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүллээ;
- Өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тохируулан интернэт банкны үйлчилгээг илүү найдвартай, аюулгүй байдал нь хангагдсан байдлаар өргөжүүлэн шинэчлэв;
- Үүрэн холбооны операторуудтай хамтран утасны төлбөрийг мессежээр төлөх болон урьдчилсан төлбөрт үйлчилгээг мессежээр цэнэглэх, и-биллинг гэх мэт электрон үйлчилгээний боломжоо өргөжүүллээ;
- МИАТ ХХК-тай хамтран онгоцны тасалбарын, Улаанбаатар Төмөр Зам Нийгэмлэгтэй хамтран галт тэрэгний тасалбарын онлайн захиалгын үйлчилгээг Монгол Улсад анх удаа тус тус нэвтрүүллээ.

Олон Улсын Агаарын Тээврийн Холбоо Монгол Улс дахь төлбөр тооцоо гүйцэтгэгчээрээ Голомт банкиг сонгож, уг төсөл амжилттай хэрэгжиж эхлэв. Ингэснээр харилцагчдын өмнө онгоцны тасалбараа тав тухтай, түргэн шуурхай худалдан авах боломж бүрдэж байгаа ба агаарын тээврийн төлбөр тооцоон дахь мөнгөний урсгалын хяналт сайжирч байна.

Банк нь интернэтийн онлайн төлбөр тооцоон дахь картын луйврын гүйлгээг бууруулах зорилгоор Виза болон Мастеркартаас баталгаажуулсан аюулгүй байдлын стандартуудыг үе шаттайгаар хэрэгжүүллээ.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ


ИРГЭДЭД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эдийн засгийн хямралыг амжилттай даван туулахын тулд Банк нь салбар сүлжээгээ өргөжүүлж, зардал өртөгийг нэмэхээс илүүтэйгээр салбар нэгжүүдийнхээ бизнесийн үйл ажиллагааг тогтвортой хангах, ялангуяа орон нутгийн салбаруудын санхүүгийн болоод үйл ажиллагааны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа. Гэсэн хэдий ч өөрийн үнэ цэнэтэй харилцагчид болох Монгол Улсын томоохон компаниудад үйлчилгээгээ улам ойртуулан тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын төв цэгт байрлах Төв цамхагт, төрийн байгууллагуудын төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх зорилгоор тухайн байгууллагуудын дэргэд, Монгол Улсын ирээдүйн хөгжил цэцэглэлтийн гол төв болсон Өмнөговь аймгийн Цогтцэций суманд банкны нэгжүүдийг шинээр байгуулж ажиллалаа. 2009 оны оны эцэст Голомт банк Улаанбаатар хотод нийт 37 нэгж, орон нутагт нийт 22 нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба АТМ-ийн сүлжээний тоо 90-д хүрсэн байна.

Банк нь солонгосын туршлагатай банкираар удирдуулсан Солонгос бизнесийн нэгжийг нээж, Баянгол дүүрэг дэх Москва салбараа шинээр баригдсан 6 давхар байрандаа шилжүүлээ.

Харилцагч үйлчлүүлэгчиддээ банкны иж бүрэн үйлчилгээг хүссэн цагт нь буюу 24 цаг 7 хоног 365 гэсэн зарчмаар түргэн шуурхай, үр ашигтай, өртөг зардал багатайгаар хүргэхийн тулд сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний сувгийг өргөжүүллээ. Үүнд:

- Түнш банкуудтай хамтран АТМ-ийн сүлжээгээ 90-д хүргэж, 2 талдаа ашигтай харилцааг хөгжүүлснээр Улаанбаатар, хөдөө орон нутаг дах АТМ -ийнхээ тоог 2 дахин нэмэгдүүлэв;
- SMS банкны үйлчилгээг бүх үүрэн холбооны операторуудын хэрэглэгч ашиглах боломжтой болгож, easy info дансны орлого зарлагыг мессежээр мэдээлэх үйлчилгээг нэвтрүүлээ;
- Төлбөр тооцоогоо гар утсаараа хийх, урьдчилсан төлбөрт картыг мессежээр авах, и-биллингийн үйлчилгээг нэвтрүүлснээр электрон үйлчилгээний хамрах цар хүрээ өргөжлөө;
- Интернет банкны үйлчилгээний боломж, аюулгүй байдлыг сайжруулаа;
- 500 гаруй байгууллагыг картын сүлжээндээ нэгтгэж, цалинг картаар олгож байна.





Голомт банк төлбөрийн картын системд тэргүүлэгч байр сууриа хадгалж Монгол Улсын картын төлбөр тооцооны 60 хувийг дангаар гүйцэтгэж байгаа ба идэвхтэй карт эзэмшигчдийн тоо 400000 давсан байна.


Голомт банк Монгол Улсад олон улсын төлбөрийн картын систем нэвтрүүлсний 10 жилийн ойгоо тохиолдуулан Монголбанк, МастерКарт Ворлдвайд байгууллагатай хамтран “Төлбөрийн картын системийн хөгжлийн хандлага” сэдэвт олон улсын бага хурлыг амжилттай зохион байгууллаа.

ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

Голомт банк 2009 оны туршид өөрийн харилцагчид, бизнесийн байгууллагуудад хэрэгцээтэй байгаа санхүүжилтийг шийдвэрлэж, тэдэнд учраад буй хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг болох зорилгоор зээлийн үйл ажиллагаагаа тасралтгүй нээлттэй байлгаж банкныхаа тогтвортой байдал болон итгэл хүлээх чадвараа амжилттай баталж чадлаа. Бид харилцагчдынхаа үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд нь дэмжлэг болохоор нягт хамтран ажилладаг. 2009 онд нийт жижиг дунд бизнесийн зээл 22.2 хувиар өсч 132 тэрбум төгрөгт хүрсэн ба олгосон зориулалтаар нь ангилж үзвэл дийлэнх нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэр байна.

Голомт банк нь харилцагчдынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээг хангахын тулд дан ганц өөрийн эх үүсвэрээс зээл олгоод зогсохгүй Сангийн яам, Хөрөнгө Оруулалтын Хөгжлийн сан, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк (IBRD), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны нийгэмлэг (JICA), Ногоон зээлийн баталгааны сан, ХБНГУ-ын Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GTZ) зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, уян хатан нөхцөл бүхий бага хүүтэй төслийн зээлүүдийг бизнес эрхлэгчиддээ олгож ирлээ.

Жижиг дунд бизнесийн зээл (тэрбум төгрөг)




ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

Банк нь өөрийн үнэ цэнэтэй харилцагчдынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээнд нь тохирсон уян хатан нөхцөл бүхий маш олон төрлийн хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн (жилийн тайлангийн 42-р хуудсанд тусгасан)-ийг санал болгож байна. Дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө хамгийн ихээр туссан барилгын салбарын бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхийн тулд өөрийн харилцагч барилгын компаниудын барилгыг дуусгахад санхүүжилт олгох, дууссан барилгаас орон сууцны зээл олгох, орон сууцгүй хүмүүсийг уг барилгын компаниудтай холбож өгөх зэрэг санал санаачлагыг идэвхтэй хэрэгжүүлээ.

Монголд хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын Ипотекийн Корпорацитай нягт хамтран ажиллаж байгаагаас гадна Монголбанкнаас “Ипотекийн зээлийн үлгэрчилсэн журам”-ийг батлан гаргахад хувь нэмэр оруулж ажиллалаа. Мөн Засгийн Газрын “40000 орон сууц” хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоор байна.

Орон сууцны зээл (тэрбум төгрөг)



БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өнгөрөгч 2009 оны зах зээлийн нөхцөл байдалд тохируулан зөвхөн тухайн байгууллагад зориулсан, бизнесийн онцлогт нь уялдуулсан банкны үйлчилгээг хүргэхэд анхаарал хандуулж, харилцагч байгууллагуудынхаа бизнесийн үйл ажиллагааг амжилттай явагдахад багагүй үүрэг гүйцэтгэлээ. Тухайлбал, тэдний онцлог хэрэгцээнд нь тохирсон




банк санхүүгийн үйлчилгээг санал болгохоос гадна эдийн засгийн уналтын үед байгууллага, бизнес эрхлэгчид мөнгө санхүүгээ хэрхэн зөв зохистой удирдах, бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн хэвийн хөтлөн явуулах зэрэг асуудлаар харилцагчдад заавар зөвлөгөө өгч, нягт хамтран ажиллав.

Түүнчлэн өнгөрөгч онд Банкны төлбөрийн чадвар, санхүүгийн зохистой харьцаанууд сайн байснаас улбаалан зээлийн үйлчилгээнд хязгаарлалт тавихгүйгээр үйлчилж, харилцагч байгууллага, бизнес эрхлэгчдэд зээлийн санхүүжилтийг зогсоогоогүй гэдгээрээ Голомт банкны байгууллагад үзүүлэх үйлчилгээ ихээхэн онцлог давуу талтай байлаа.

2009 онд дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн банкны үйлчилгээг хүргэх чиглэлд анхааран ажиллаж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд нөлөө бүхий томоохон бизнес эрхлэгчдэд зээл, зээлийн шугам, хамтарсан зээлжүүлэлт, аккредитив, тендерийн баталгаа, баталгааны шугам, төлбөрийн баталгаа, дахин санхүүжилт, төслийн санхүүжилт зэрэг өргөн цар хүрээтэй санхүүжилтийн үйлчилгээ үзүүлж санхүүгийн түншлэлийг амжилттай хэрэгжүүллээ.

Байгууллагад зориулсан бизнесийн зээл (тэрбум төгрөг)



Банкны хамтран ажиллагч байгууллагууд өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа бөгөөд манай улсын хувийн хэвшлийн томоохон бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид, түүхий эд болон бараа бүтээгдэхүүн экспортлогчид болон машин тоног төхөөрөмж, түлш шатахуун, барилгын материал, гурил тэжээл, хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн импортлогчид мөн түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбооны салбарын төрийн байгууллагуудад санхүүгийн үйлчилгээ үзүүлж, улмаар өнгөрөгч онтой харьцуулахад харилцагч байгууллагуудаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр болон байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг өсгөсөн үзүүлэлттэй байна.

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

Төслийн Санхүүжилтийн Хэлтэс нь олон улсын болон төслийн байгууллагад банкны үйлчилгээ хүргэх, зээлийн төсөл хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа ба бизнес эрхлэгчдийг дэмжих, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх чиглэлээр дунд болон урт хугацааны зээлийн төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Банкны харилцагч бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн Газар болон дотоод гадаадын донор байгууллагуудтай хамтран дунд болон урт хугацааны зээлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны санхүүжилт бүхий “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл”;
- Олон Улсын Хөгжлийн Ассоциаци буюу Дэлхийн Банкнаас санхүүжилттэй “Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл”;
- Монгол улсын Засгийн Газрын Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Сангийн санхүүжилттэй “Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхлэгчдэд хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох төсөл”;
- Нидерландын Засгийн Газраас санхүүжилттэй Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ногоон Зээлийн Баталгааны Сантай хамтран “Эрчим хүчний хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” болон “Жижиг дунд бизнесийг дэмжих, зээлийн баталгаа гаргах хөтөлбөр”;
- ХХААХҮЯ-ны ЖДҮСангаас санхүүжилттэй “Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”;
- Германы Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Зээлийн баталгааны сангийн төсөл”;
- Азийн Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлдэг “Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл” зэрэг болно.

Банкны зүгээс олон улсын төслийн байгууллагуудтай зээлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн хамтран ажиллахын зэрэгцээ Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /Жайка/, Дэлхийн банк, БОАЖЯ-ны Цэвэр Хөгжлийн Механизмын Үндэсний Товчоо зэрэг байгууллагуудтай хамтран харилцагчдад зориулсан сургалт семинар зохион байгуулж, мэдээлэл зөвлөгөө өгсөн.



Мөн түүнчлэн Голомт банк нь 2009 онд Монгол Улсад анх удаа Цэвэр Хөгжлийн Механизмын төслийн дагуу агаарын бохирдол, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр харилцагчдад банкны үйлчилгээ үзүүлж эхэлсэн, Германы Сэргээн Босголтын Банкны Нүүрсхүчлийн Хийн Сантай хамтран ажиллах гэрээ байгуулсан зэргээр зах зээлд тэргүүлэн ажиллалаа.

УУЛ УУРХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Банкны Уул Уурхайн Хэлтэс нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад банкны үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байгаа ба салбарын онцлогийг сайтар мэдэх мэргэжлийн туршлагатай экспертүүд болон менежерүүд ажилладгаараа онцлог давуу талтай.

2009 онд тус хэлтсээс уул уурхайн салбарын 50 гаруй аж ахуйн нэгжид банкны үйлчилгээг хүргэсэн ба салбарын онцлогт тохирсон ашигт малтмалын зээл болон хүнд машин механизмын санхүүгийн түрээсийн үйлчилгээ зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Банкны Уул уурхайн хэлтэс нь алтны олборлолт болон боловсруулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд Засгийн Газраас санхүүжүүлсэн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж Монголын уул уурхайн салбарын хөгжилд идэвхтэй оролцож байна. Тус хэлтэс нь энэхүү салбарын бизнес эрхлэгчдийн онцлогоос хамаарч, банк санхүүгийн цогц үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хүргэх, мэргэжлийн холбогдох мэдээ судалгаануудыг бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг бөгөөд манай банкны хүндэт үйлчлүүлэгчид болон хөрөнгө оруулагчиддаа зориулан Монголын уул уурхайн салбарын талаар өргөн хүрээний судалгааг гаргахын тулд Хөрөнгө Оруулалтын Банкны газартайгаа нягт хамтран ажилладаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлхийн томоохон хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зах зээлийн анхаарлын төвд орж эхлээд буй хөрөнгийн зах зээлийг Монгол Улсад хөгжүүлэх эхний алхмууд тавигдаж эхлээд байгаагийн нэг нь Голомт банк Хөрөнгө Оруулалтын Банкны газрыг байгуулсан явдал юм.

Хөрөнгө Оруулалтын Банкны газар нь Хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр үйл ажиллагаа явуулах, Монгол Улсын хөгжилд ихээхэн ач холбогдолтой ч хөрөнгө дутагдалтай салбаруудад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хамтарсан зээлжүүлэлтийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасжуулалтыг бий болгох, компанийн өөрийн хөрөнгө босгох урт болон богино хугацаат санхүүжилтыг бий болгох, зөвлөгөө өгөх, хөрөнгийн менежментийн үйл ажиллагаа явуулах, хувьцаа худалдах, худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийхэд туслах зэрэг үйлчилгээг харилцагчдад үзүүлэх зорилготой.

Тайлант онд банк нь дэлхийн тэргүүлэгч BNY Меллон болон Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран “Хөрөнгө босгох шинэ боломжууд” сэдэвт олон улсын хурлыг амжилттай зохион байгуулаа.

ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ БА ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО

Гадаад Худалдааны Санхүүжилтийн Хэлтэс нь гадаад худалдааны төлбөр тооцоо, санхүүжилтийн дэвшилтэт хэлбэр болох аккредитивийн үйлчилгээг хүргэн ажилладаг.

Гадаад худалдааны аливаа эрсдэлээс бүрэн хамгаалагдсан, байгууллагын мөнгөн урсгалд үр ашигтай нөлөө үзүүлэгч гадаад санхүүжилтийн үйлчилгээний ач холбогдлыг харилцагчдад ойлгуулах, мэдээлэл зөвлөгөө өгөх, импортын болон экспортын аккредитив нээх үйлчилгээгээ банк өргөжүүлэн ажилласан ба 2009 онд нээгдсэн экспортын аккредитивийн мөнгөн дүн өмнөх оноос 115 хувиар өссөн байна.



Мөн Грэйпбанк системийн үндсэн систем болох аккредитив, баталгаа, инкасс нээхээс эхлээд төлбөр нь хийгдэж хаагдах хүртэлх бүхий л үе шатын бүртгэл, төлбөр тооцоо, нягтлан бодох бүртгэл, хяналт, тайлан мэдээг автоматжуулсан ГРАФТ программыг үйл ажиллагаагаа хөнгөвчилж, сайжруулах зорилготой нэвтрүүлэн, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

НӨӨЦИЙН БОЛОН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НӨӨЦ БА ХӨРВӨХ ЧАДВАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2009 онд өрнөсөн эдийн засгийн тодорхойгүй, бэрхшээлтэй нөхцөл байдал болон банкны системийн хадгаламжийн өсөлтийн хямралын үед банкны актив, пассивын бодлого илүү хянуур, хамгаалагдсан байдалтай байсан. Банк нь жилийн туршид хөрвөх чадварын байр сууриа бэхжүүлэхэд анхаарч ирсэн ба дотоодын банкны системд хамгийн өндөр нөөцийг эзэмшигч байр суурьтай байлаа.


Жилийн хоёрдугаар хагаст, дэлхийн болон дотоодын эдийн засгийн нөхцөл байдал сайжрахад бид уламжлалт консерватив зээлийн бодлого барьж, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхийн сацуу татан төвлөрүүлсэн хөрөнгө болон зээлийн хувьд зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх байдлыг хослуулсан илүү өргөн хүрээний бизнес хөгжлийн бодлого барьж ажилласан.

Төв банкны үнэт цаас эзэмших хэмжээ нь 180 хувиар өссөн ба энэ нь 2009 онд олгосон Монгол Банкны нийт үнэт цаасны 35 хувийг эзэлж буй юм. Жилийн хоёрдугаар хагаст, банк хоорондын зах зээл дэх үйл ажиллагаа нь идэвхжиж эхэлсэн бөгөөд Банк нь зах зээл дэх гол зээлдүүлэгч хэвээр ноёрхож байна.

ГАДААД АКТИВ БОЛОН ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2009 оны төгсгөл гэхэд Монголын 15 арилжааны банкны нийт гадаад активд 405,1 тэрбум төгрөг цугларсан байсан бөгөөд үүний 218,1 тэрбум төгрөг буюу 53,8 хувь нь Голомт банкных байлаа. Харин жилийн эхний саруудад төгрөгийн тогтвортой байдлын хувьд Голомт банк нь төгрөг болон ам.долларын хоёр талын гадаад валютын гүйлгээнд давамгайлах байр сууриа хадгалж 3.5 тэрбум ам.долларын системийн нийт гүйлгээний 40 хувийг буюу 1.4 тэрбум ам.долларын гүйлгээг бие даан гүйцэтгэлээ.

Банкны системийн гадаад активд эзлэх
Голомт Банкны хувь





САНХҮҮГИЙН ҮР ДҮН

2009 онд, эдийн засаг, санхүүгийн зах зээл хүндрэлтэй байсан хэдий ч Голомт банк стратеги болон санхүүгийн төлөвлөгөө, зорилтуудаа амжилттай биелүүлж, хамгийн тэмдэглүүштэй нь түүхэндээ анх удаа активын хэмжээгээ нэг их наяд төгрөг давууллаа.

2009 оны эцэст, банкны нийт активын хэмжээ 2008 оны 697.2 тэрбум төгрөгөөс 45.3 хувь буюу 315.9 тэрбум төгрөгөөр өсч 1,013 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны системийн 21 хувийн өсөлтөөс өндөр гарчээ.

Санхүүгийн тайлангийн үндсэн харьцаанууд зохистой гарсан бөгөөд зээл/хадгаламжийн харьцаа 63.5 хувь гарсан нь банкны системийн дундаж үзүүлэлт болох 82 хувиас бага сайн үзүүлэлт хэвээр хадгалагджээ.



Бид хөрвөх чадвар, санхүүжилтийн уламжлалт бодлогоо баримталж, амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 2009 онд банк санхүүгийн зах зээлд санхүүжүүлэгч буюу төлбөрийн чадвар хамгийн сайтай банк байж чадлаа. 2008 оны эцэст 37 хувьтай байсан хөрвөх чадварын харьцаа 2009 онд 51.7 хувь болж өссөн байна.



Харилцагчдын харилцах, хадгаламж 57.4 хувь буюу 290.1 тэрбум төгрөгөөр өсч 795 тэрбум төгрөгт (551.2 сая ам.доллар) хүрсэн нь системийн дундаж өсөлт 29 хувиас харьцангуй өндөр үзүүлэлт гарчээ.



Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байсан хэдий ч чанаргүй зээлийн хувь хэмжээ 2007 оны түвшинд хадгалагдаж 4.4 хувьтай гарсан нь зээлийн эрсдэлийн бодлого журмын үр ашигтай байдал, зээлийн үйл ажиллагааны хяналт, сайжруулалтын үр дүн юм.



Орлогын бүх төрлийн өсөлт, үр ашигтай зардлын удирдлагын үр дүнд 2008 онд 12,201 сая төгрөг байсан татварын дараах ашиг 968 сая төгрөг буюу 7.9 хувиар өсч 13,170 сая төгрөгт хүрсэн.


Нэг ажилтанд ноогдох татварын дараах ашиг 9 хувиар өсч 15.2 сая төгрөг хүрсэн бөгөөд зардал/орлогын харьцаа 2009 онд харьцангуй тогтмол 44.9 хувьтай (2008 онд 43.8 хувь) байна.






Нийт үйл ажиллагааны орлого 2,599 сая төгрөгөөр өсч 37,260 сая төгрөгт, үйл ажиллагааны зардал 1,534 сая төгрөгөөр өсч 16,712 сая төгрөгт тус тус хүрчээ. 2009 онд дундаж активын өгөөж 1.6 хувь, дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 22.5 хувь гарчээ.

Дундаж активын өгөөж (%)




Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)




2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт өөрийн хөрөнгө 78.5 тэрбум төгрөгт хүрч, эрсдэлээр жигнэсэн актив өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 13.4 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарлалт 12 хувь болон Базелийн Хорооноос гаргасан стандарт 8 хувиас өндөр сайн үзүүлэлт байна.

Нийт өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (%)





ТАВАН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

	2005	2006	2007	2008	2009
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	273,253	353,161	652,051	697,179	1,013,109
Нийт харилцах, хадгаламж	232,838	283,707	512,485	505,171	795,251
Цэвэр зээл	131,817	174,700	323,026	447,787	505,299
Нийт өөрийн хөрөнгө	20,275	35,794	54,871	63,548	78,471
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	19,632	26,955	44,564	69,318	81,832
Хүүгийн зардал	(13,284)	(18,283)	(30,228)	(43,569)	(57,905)
Цэвэр хүүгийн орлого	6,348	8,672	14,336	25,749	23,927
Цэвэр хүүгийн бус орлого	4,249	3,698	7,231	8,912	13,333
Үйл ажиллагааны зардал	(4,450)	(6,179)	(10,078)	(15,178)	(16,712)
Эрсдэлийн сангийн зардал	(2,708)	(2,563)	(2,299)	(3,958)	(3,240)
Татварын зардал	(1,057)	(1,109)	(1,811)	(3,324)	(4,138)
Татварын дараах ашиг	2,381	2,520	7,378	12,201	13,170
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж/Нийт актив	85.2%	80.3%	78.6%	72.5%	78.5%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл)/Нийт актив	7.4%	8.9%	5.9%	7.3%	6.3%
Цэвэр зээл/Нийт актив	48.2%	49.5%	49.5%	64.2%	49.9%
Цэвэр зээл/Нийт харилцах, хадгаламж	56.6%	61.6%	63.0%	88.6%	63.5%
Чанаргүй зээлийн харьцаа (%)	8.6%	6.7%	4.2%	3.9%	4.4%
Хөшүүргийн харьцаа (дахин)	12.5	8.9	10.9	10.0	11.9
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.1%	0.8%	1.6%	1.8%	1.6%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	14.4%	10.7%	17.3%	24.3%	22.5%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	3.8%	4.0%	4.1%	4.2%	4.1%
Зардал, орлогын харьцаа (%)	42.0%	50.0%	46.7%	43.8%	44.9%
Эрсдэлийн үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн үзүүлэлт >12%	12.3%	16.7%	14.4%	12.8%	13.4%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд <+/-40%	32.4%	39.7%	8.1%	11.9%	11.8%
Нэгж гадаад валютын хувьд <+/-15%	14.8%	14.3%	5.8%	9.5%	10.0%
Нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгосон					
зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <20%	18.3%	18.3%	17.5%	19.5%	19.9%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн					
хөрөнгөнд эзлэх хувь <5%	0.1%	1.7%	2.7%	3.7%	3.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >=18%	51.7%	53.2%	49.3%	37.0%	51.7%
Үндсэн хөрөнгийн харьцаа <=8%	1.2%	1.1%	1.0%	1.0%	0.7%



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

2009 онд дэлхий дахинд өрнөсөн үйл явдал нь бусад салбаруудтай харьцуулахад банкны салбарт зөв зохистой үйл ажиллагаа, эрсдэлийн оновчтой удирдлага хамгийн чухал гэдгийг дахин тод нотлон харууллаа. Банкнаас гадна цөөн хэдэн салбарын хувьд урт хугацааны бизнесийн амжилтанд эрсдэлийг тооцох, тодорхойлох, арилгах асуудал чухлаар тавигддаг бөгөөд энэхүү үйл ажиллагаанд Эрсдэлийн Удирдлагын газар хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг. 2009 онд бизнесийн орчинд үүссэн хүчтэй уналт, эмзэг байдлын эсрэг арга хэмжээ авах, нөхцөл байдлыг хохиролгүйгээр даван туулахын тулд Эрсдэлийн Удирдлагын газар үйл ажиллагаагаа илүү хүчирхэгжүүлж ажиллав.

Мөн Банкны бусад нэгжүүдийн хамтаар зээлдэгчидтэйгээ нягт хамтран, тэднийг дэмжин ажиллахын зэрэгцээ санхүүгийн тодорхойгүй нөхцөл байдалд хэрхэн ажиллах, хэрхэн давуу тал олох болон санхүүгийн сахилга батыг хэрхэн хамгийн өндөр түвшинд сахих талаар сургалт, зөвлөгөөг хүргүүлж ажилласан.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ


Голомт банкны Зээлийн бодлого нь Базелын хорооноос 2000 оны 9 сард гаргасан зээлийн эрсдэлийг удирдах шаардлагуудыг бүрэн хангасан. Энэхүү шаардлагууд нь 16 дүрмээс бүрддэг бөгөөд банкны системд эрсдэлийг удирдах талаар заавар өгдөг.

Зээлийн бодлого нь банк, зээлдэгчийн аль алинд харилцан ашигтай нөхцөлийг бүрдүүлэх замаар зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулахад чиглэгддэг. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зээлийн бодлогыг ойрын ирээдүйд эдийн засаг хурдацтай өснө гэсэн таамаглалд үндэслэсэн ба үүний үр дүнд зээл олголтод хянамгай байр суурийг баримтлах боловч зээл олголтын хэмжээ ихээр өснө.

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл, Эрсдэлийн Удирдлагын Хороо, Удирдлагын Баг нь зээлийн бодлого стратегийг батлах, гүйцэтгэлийг цаг тухайд нь тогтмол хянах үүрэгтэй. Голомт банк Зээлийн бодлогоо өөрийн бизнесийн стратегийн дагуу эдийн засгийн өөрчлөлтийг даган шинэчилж ирсэн.

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь мөн үндсэн харьцаануудыг тодорхойлох, нийт актив, хадгаламжийн харьцаа гэх мэт тайлан тэнцлийн зохистой харьцаануудыг тодорхойлох үүрэгтэй. Голомт банк зээлийн эрсдэлийг сайтар зохион байгуулсан бүтцээр удирддаг.

Банк нь зөвхөн гадаад валютын тогтмол орлого олдог, уг валютын орлогоороо орлогын найдвартай байдлаа хадгалах компаниудад валютын зээл олгох байдлаа өргөжүүлсэн.



Голомт банк 2009 онд зээл хүсэгчдийн зээлээ төлөх чадварыг үнэн зөв бодитоогоор дүгнэхийн тулд зээлийн үнэлгээний системийг нэвтрүүлсэн. Энэхүү систем нь үндсэндээ эдийн засгийн байдал, зээл хүсэгчийн үйл ажиллагаа явуулдаг бизнесийн салбар, зээл хүсэгчийн бизнесийн байдлыг тус тус судлаад 1-9 хооронд үнэлгээ өгдөг. Энэхүү үнэлгээний утгууд нь олон улсад нийтлэг хэрэглэгддэг AAA, AA, A, BAA, BA, B, CAA, CA, C гэсэн утгуудтай дүйх юм. Зээлийн эрсдэлийн энэхүү систем шинээр зээл олгох болон олгосон зээлийг дүгнэхэд хэрэглэгдэнэ.

2009 оны эдийн засгийн уналтын үед банк голлох зээлийн бодлого, журмуудаа шинэчилж, эрсдэлийн хязгаарлалт, зээлдэгчдэд тавигдах шаардлагуудыг илүү нарийсгаж, эрсдэлийн хяналтыг чангатган ажиллав. Үүний үр дүнд 2009 онд банкны зээлийн багцын чанар 2008 онтой харьцуулахад муудаагүй юм.

ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

Зээлийн ажилтнууд нь зорилтот харилцагчидтай харилцаж, тэдний бизнесийн үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж буй салбарын талаар гүн гүнзгий мэдлэгтэй болж, улмаар зээлдэгчдийн санхүүгийн чадавхи болон бизнесийн дотоод мөн чанарыг мэдэхийн тулд маш дэлгэрэнгүй санхүүгийн болон техникийн дүн шинжилгээ хийдэг.

Тэд санхүүгийн болон бизнесийн дүн шинжилгээг хийсний дараа зээл олгох эсэх саналаа Байгууллагын Банкны газрын удирдлагад болон Эрсдэлийн Удирдлагын газарт явуулдаг. Нийтдээ 50 сая төгрөг болон түүнтэй тэнцэх валютаас дээш дүн бүхий бүх зээлүүд Зээлийн хороогоор орж хэлэлцэгдэхээс өмнө Эрсдэлийн Удирдлагын газраар хянагддаг.



Эрсдэлийн Удирдлагын газар нь Байгууллагын Банкны газраас ирсэн зээлийн саналуудыг хянаж үзээд дараах дүн шинжилгээг хийдэг.

1. Уг зээлдэгч зээлийн мэдээллийн санд түүхтэй эсэхийг судлах;
2. Зээлийн санал дээр бие даасан шинжилгээ хийх;
3. Банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой дараах шинжилгээнүүдийг хийж дүгнэх:
 - Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хязгаарлалт, салбарын хязгаарлалтанд тохирч буй эсэх;
 - Нэг зээлдэгчид болон холбоотой этгээдэд олгох зээлийн хэмжээнд тохирч буй эсэх;
 - Үнийн хувь хэмжээ;
 - Зээлийн багцийн хугацааны тохиромжтой байдал;
 - Зээлийн багцийн бүтцэд тохиромжтой байдал.

Зээлдэгчийн нөхцөл байдал, боломж бололцоог судалж шинжилснээр зээл болон зээлийн хүүг эргэн төлөх үүрэг хариуцлага, зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг хангаж буй эсэх, зээлийн хязгаарлалтыг хэтрүүлээгүй эсэх, зээл олголтоос бий болох хүндрэлүүд байгаа эсэх зэргээр эрсдэлийн дүн шинжилгээг хийдэг.

Зээлийн саналыг туршлага бүхий зээлийн ажилтнууд тухайн зээлдэгчийн зээл төлөх чадвар, зээл авах хэрэгцээ шаардлага дээр уялдуулан гаргадаг бөгөөд уг зээлийн саналыг хамгийн багадаа хоёр зээлийн ахлах ажилтан хянаж, зээлийн дэд хороо болон зээлийн хороогоор орж шийдүүлдэг.

Банкны зээлийн шийдвэр гаргах эрхийн хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

- Салбарын зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ 30 сая төгрөг хүртэл буюу 20,000 ам.доллартай тэнцэх хүртэл валют;
- Дэд зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ 200 сая төгрөг хүртэл буюу 138,000 ам.доллартай тэнцэх хүртэл;
- Зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ

Банкны эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц нь тоон болон чанарын хүчин зүйл дээр үндэслэн харилцагч бүрийн зээлийн эрсдэлийг тус бүрд нь тодорхойлоход чиглэгдсэн байдаг. Дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж эрсдэлийн үнэлгээг хийдэг. Үүнд:

- Зан төлөв: зээлийн түүх;
- Зах зээлд эзлэх байр суурь: зах зээлд эзлэх хувь, нэр хүнд;
- Удирдлага:
 - Үр ашигт байдал – Ашигт ажиллагаа, маржин, нийт активын өгөөж;
 - Маркетинг – Борлуулалтын өсөлт;
 - Бүтээгдэхүүний менежмент – нийт активын эргэц, дансны авлага, түүхий эд материал;
- Санхүүгийн байдал: Хөрвөх чадвар, өр төлбөр, нийт актив;
- Салбарын тогтвортой байдал: Боломж болон аюулууд;
 - Харилцагчийн зан төлөв;
 - Өрсөлдөөн;
 - Бэрхшээл дарамт: Засгийн Газраас тогтоосон хязгаарлалтууд, шинээр хөрөнгө оруулалт татах боломж, зах зээлийн багтаамж.

Зээлийн эрсдэлийн үнэлгээ нь 1-10 гэсэн тоогоор илэрхийлэгдэх ба 1 гэсэн үнэлгээ нь хамгийн бага, 10 гэсэн үнэлгээ нь хамгийн өндөр эрсдэлтэй байна. Зээлийн эрсдэлийн үнэлгээ ямар байх нь зээл олголтын хязгаарыг тогтоох, зээл олгох саналыг зөвшөөрөх, татгалзах эсэхэд нөлөөлдөг.



Эрсдэлийн Удирдлагын газар нь банкны зээлийн багцийг бүхэлд нь хянадаг ба зээлийг “хянах жагсаалт”-ын аргаар зээлийн ангилалыг өөрчилж, сар бүрийн хяналтыг хийж байдаг. Зээлийн хяналтын явцад эрсдэлийн түвшин болон салбарын эрсдэлээр нь зээлийн багцын чанарын ангилалыг хийдэг.

Зээлийн ажилтнууд нь зээлийн үйл ажиллагааныхаа өдөр тутмын хяналтыг хийх үүрэгтэй байдаг ба холбогдох хэлтэс, бүтээгдэхүүн үйлчилгээг хариуцсан менежерүүд нь зээлийн эрсдэлийн ахлах менежертэй энэхүү үйл ажиллагаан дээр хамтран ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын газар нь Эрсдэлийн Удирдлагын Хороонд үйл ажиллагааны тайлангаа тавьдаг бөгөөд тайланд аа зээлийн чанар, эрсдэлийн түвшин болон анхаарах шаардлагатай асуудлуудыг тусгасан байдаг.

ЗЭЭЛ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг зээлийн ажилтнууд хариуцдаг. Бүх харилцагчдад зээлийн эргэн төлөлттэй холбоотой үйл ажиллагааг бичгээр болон аман хэлбэрээр мэдэгддэг ба зээлийг эргэн төлүүлэх чиглэлээр эрчимтэй ажилладаг.

Зээлийг эргэн төлөх хугацаа хэтэрснээс хойш тав хоногийн дотор Зээлийн түүх болон, өмнө хугацаа хэтрүүлж байсан эсэх, зээлийн хэмжээ зэргээс хамаарч харилцагч нартай зээлийн эргэн төлөлтийн талаар холбоо тогтоодог. Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ өндөр байгаа болон зээлийг эргэн төлөх түүх нь удаашралтай байгаа харилцагчдад илүү анхаарал тавьж, тогтмол эргэх холбоотойгоор ажилладаг. Байгууллагын Банк болон Иргэдийн Банкны газрын удирдлага зээлийн хугацаа хэтрэлттэй харилцагчдад эхний удаад утсаар мэдэгдэж холбоо тогтоох ба уг харилцааны үр дүн ямар байгаагаас хамаарч дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Бүх зээлдэгчидтэй харилцах бичиг болон аман харилцаа нь мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн шаардлагыг хангасан байдлаар явагддаг.

Зээлийг эргэн төлүүлэх үйл явцыг тоймловол:

- Бүх зээлдэгчид сар бүр зээлийн дансны хуулга, зээл төлөгдсөн байдал, зээл төлөх хэмжээ, хугацаа хэтрэлтийн мэдээллийг агуулсан тайлан мэдээг хүлээж авдаг. Зээлийн ажилтан нь зээлийн дансууддаа хяналт тавьж зарим сонгосон дансуудыг Эрсдэлийн Удирдлагын газартай хамтран хяналт хийдэг. Үүний дагуу хугацаа хэтэрсэн болон муудсан зээлтэй зээлдэгчээр зээл төлүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг.
- 30-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн зээлдэгчдэд зээлийн ажилтнууд нь бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн явуулах, мөнгөн урсгалаа хэрхэн зөв удирдах, маркетинг борлуулалтаа хэрхэн сайжруулах, үнийн ямар бодлого барих гэх мэт зөвлөгөө өгч ажилладаг.
- Бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэний дараа 90-ээс дээш хоног хугацаа хэтрээд байгаа зээлийн хувьд Эрсдэлийн Удирдлагын газрын хяналтад шилждэг.
- Зээлийн эргэн төлүүлэх бүхий л боломжийг судалж ажилласны дараа ямар нэг маргаан гарсан, эсвэл зээл төлөх чадваргүй болсон тохиолдолд Тусгай Активын хэлтэст шилжүүлдэг. Тус хэлтэс нь 30 хоногийн дотор хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээг авдаг.

ЭРСДЭЛТЭЙ ЗЭЭЛИЙГ УДИРДАХ НЬ

Банк нь өндөр чадвар, туршлага бүхий мэргэжилтнүүдээр асуудалтай зээлийг удирдуулдаг. Тусгай активийн менежерүүд нь зээлийн эргэн төлөлт удааширсан, асуудалтай зээлүүд дээр шинжилгээ хийж ажилладаг.

Уг менежерүүд нь асуудалтай зээлүүдийг аль болох богино хугацаанд төлүүлэх, хөрөнгийг найдвартай хамгаалах үүднээс бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба төлүүлэхдээ зээлдэгчийн зан төлөв, зээлийг эргэн төлөх хүсэл сонирхолтой байгаа эсэх гэх мэт бүх нөхцөл байдлыг дүгнэж авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ сонгодог. Зээл төлүүлэх менежер нь тухайн зээлийг шүүхийн байгууллагад шилжүүлж төлүүлэх ч тохиолдол гарч болзошгүй байдаг. Шүүхийн байгууллагаар асуудал шийдвэрлүүлэх хугацаа дунджаар 6-12 сар байдаг ба шүүхийн байгууллагад шилжүүлэхээс өмнө банк нь мэргэжлийн экспертийн зөвлөгөөгөөр тусгай үнэлгээг хийж, барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ, шүүхээр эргэн төлүүлэх нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тогтоодог.



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗАГВАРЧЛАЛ БА БАГЦЫН ЧАНАР

Бид зээлийн хугацаа хэтрэлт (PD), алдагдлын магадлал (LGD) болон зээлийн эрсдэлийн бусад үзүүлэлтүүдийг тооцоолох загварчлалыг боловсруулан ашиглаж байна. Уг аргачлал нь IAS 39 болон Базелын хорооноос гаргасан Зээлийн эрсдэлийн загварчлалын шаардлагуудыг бүрэн хангасны үндсэн дээр хөндлөнгийн хяналтын Ernst & Young компаниар баталгаажуулагдан, хүлээгдэж буй хугацаа хэтрэлт, алдагдлын хэмжээг тооцоолон, зээлийн эрсдэлийн хязгаарлалтууд, бусад зохист параметруудийг тогтоох замаар зээлийн эрсдэлийг хянах үр ашигтай хэрэгсэл гэдэг нь батлагдсан болно.

Чанаргүй зээлд хугацаа нь хэтэрсэн болон чанар нь муудсан зээлүүд хамаарагдана. Зээлийн чанарын ангилал нь IFRS 7 стандартын дагуу тогтоогддог бөгөөд IFRS 7 нь чанаргүйтсэн зээлийн өнөөгийн үлдэгдэл нь түүний ирээдүйн мөнгөн урсгалаас төлөгдөх зээл, хүүний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс өндөр байх ёстой гэж заадаг. Энэхүү дүрэм зээлийн чанарын ангилалд зээлдэгчийн давуу болон сул талууд мөн гадаад хүчин зүйлүүдийг оруулах ёстойг харуулж байна.



Графикаас харахад зээлийн хугацаа хэтрэлт (PD) 11.7-аас 2.6, алдагдалын магадлал (LGD) 6.5-аас 3.4 болж тус тус буурчээ.

САЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ БА ТӨВЛӨРӨЛ


Зээлийн багцын чанарыг урьдчилан тодорхойлсон түвшинд барих үүднээс төвлөрлийн хязгаарлалтыг тогтоож, хэрэгжүүлдэг. Бизнесийн нэг салбарт, эсвэл эдийн засгийн аль нэг сегментэд зээлийн хэт төвлөрөл үүсэхээс зайлсхийхийн тулд банкны зээлийн бодлогод эдийн засгийн нэг салбарт олгох зээлийн дээд хэмжээг нийт багцын 30 хувиас хэтрэхгүй байхаар заасан.

Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, холбоотой буюу групп зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээ болон рейтинг, улс орны хязгаарлалт зэрэг үзүүлэлтүүд ч зээлийн бодлогод тусгагдсан байдаг.

2009 оны эцэст банкны нийт зээлийн багцын 30 хувиас доош буюу 22 хувь нь болох 114 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгосон зээл, 17.6 хувь буюу 91.2 тэрбум төгрөгийг уул уурхай, боловсруулах үйлдвэрийн салбарт олгосон зээл эзэлж байна. Банкны үлдсэн зээлийн багц 8 салбарт жигд тархсан байгааг доорх зургаас харж болно.



Банкны актив хөрөнгө эдийн засгийн салбараар (тэрбум төгрөг)



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь банк өөрийн санхүүгийн үүргүүдээ цаг хугацаанд нь зах зээлийн үнээр гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэл юм. Санхүүгийн үүргүүд гэдэгт хадгаламж эзэмшигчдэд өгөх өглөг, санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний дагуух төлбөрүүд, үнэт цаас, зээл, худалдан авалтын төлбөр тооцоонууд болон хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой бүхий л үүргүүдийг ойлгоно.

Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд дээр дурьдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшингүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг. Актив Пассивын Хороо нь банкны хөрвөх чадварын эрсдэлд хандах хандлагыг тусгасан, холбогдох дүрэм, журам болон олон улсын шалгарсан, практикт нийцсэн хөрвөх чадварын эрсдэлийн стандартуудыг тогтоодог ба энэ нь банкны хэмжээнд мөрдөгдөх хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэм хэмжээ болдог. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудын хэрэгжилтийг хангуулах үүргийг Актив Пассивын Хороо гүйцэтгэдэг.

Банкны хөрөнгийн удирдлагын нэгдсэн бодлогын дагуу Актив Пассивын Хороо хөрвөх цогц удирдлагын доорх элементүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнд:


- Урт, богино хугацааны мөнгөн урсгалын удирдлага;
- Балансын зөв, сайн бүтцийг тогтоох, хадгалах;
- Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага;
- Эх үүсвэрийг хангалттай тархаах, төвлөрлийг багасгах;
- Хөрвөх чадварын стресс тестийг тогтмол хийх;
- Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Өргөн хүрээтэй дотоод хяналтын системийн тусламжтайгаар дээрх элементүүдийн өөрчлөлт, тэдгээрийн нөлөөллийг сард 2 буюу түүнээс дээш удаа хянаж, дүгнэн үр дүнг Актив Пассивын Хорооны хуралд танилцуулдаг. Энэхүү дотоод хяналтын систем нь зорилтот технологиуд, батлагдсан дүрэм журмуудын хэрэглээ болон системийн үр ашигт байдлыг үнэлэх эрсдэлийн удирдлагын бие даасан, гэнэтийн болон тогтмол хяналтыг агуулдаг.

Доорх хүснэгтэд банкны хөрвөх чадварын харьцааг, графикт хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны шинжилгээний үр дүнг харуулав.

Хөрвөх чадварын харьцаа	Хугацаагүй	
	2009	2008
12 сарын 31	51.7%	37.0%
Жилийн дундаж	44.8%	40.9%
Хамгийн өндөр	57.2%	48.4%
Хамгийн бага	35.4%	30.9%

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ





МӨНГӨН УРСГАЛЫН УДИРДЛАГА

Үр ашиг бүхий идэвхтэй хөрөнгийн удирдлага нь хэд хэдэн бүтэц нэгжүүдийн үйл ажиллагааг хамардаг бөгөөд Хөрөнгийн Удирдлагын газар удирддаг. Богино хугацааны мөнгөн урсгалын төсөөлөл нь банкны бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах шаардлагаар төлөвлөгддөг бөгөөд Актив Пассивын Хороонд шаардлагууд, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Харин урт хугацааны төлөвлөлтийн хэрэгцээ нь төсөөлсөн балансын бүтэц, санхүүгийн хэрэгслүүдийн байршлыг зохицуулах шаардлагаас урган гарч, тогтмол хугацаанд шалгагдан, сайжруулагдаж байдаг.

БҮТЦИЙН ШААРДЛАГУУД

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ нь хөрвөх чадварыг балансын бүтцээр удирдах үр ашигтай цогц удирдлагын тогтолцооны суурь болдог. Хүлээгдэж буй мөнгөн урсгал нь эргэн төлөгдөх хугацаа өөрчлөгдөх бүрт материаллаг дүнгээр өөрчлөгдөж байдаг. Иймд банкны хөрөнгө, эх үүсвэр болон тэнцлийн гадуурх үүргүүдийг эргэн төлөгдөх хугацааны хувьд шинжлэхдээ хугацаа нь тодорхоогүй, эсвэл хугацаанаас өмнө хэрэгжих магадлалтай үүргүүдийг мөн чанарын хувьд ангилж, хугацааны боломжуудыг тодорхойлдог. Энэхүү үйл явц нь балансын бүтэц алдагдсанаас үүсэх хөрвөх чадварын эрсдэлийн хэмжээ, түүнийг нөхөхөд зарцуулагдах нэмэлт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ашиглагддаг.

Хугацааны ялгаатай үеүд дэх хүлээгдэж буй орох, гарах хөрөнгийн урсгалын зөрүүг тодорхой хязгаарт барих, хөрвөх чадварын харьцааг хангалттай өндөр түвшинд байлгах үүднээс зохих хязгаарлалт, шаардлагуудыг тогтоон мөрддөг. Энэхүү хязгаарлалт, шаардлагуудыг хангуулах үр ашиг бүхий механизмуудын нэг нь богино хугацааны хөрөнгө, эх үүсвэрийн харьцаа (shot-term funding ratio)-г тогтоож, үр ашигтайгаар удирдах юм.

Түгээмэл хэрэглэгддэг харьцаанууд нь:

- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- Монгол банкинд байршуулсан хадгаламж + Мөнгөн хөрөнгө / Харилцах, хадгаламж;
- Нэг сар хүртэлх хугацааны актив/Нэг сар хүртэлх хугацааны пассив;
- Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө /Харилцах, хадгаламж;
- Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж/Харилцах, хадгаламж;
- Хөрвөх актив / Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө;
- Хөрвөх актив / Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө +Хүлээж болзошгүй үүргүүд;
- Хөрвөх актив / Нийт актив;
- Цэвэр зээл / Нийт актив;
- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- Цэвэр зээл / Харилцах хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө;
- Хугацаатай хадгаламж / Нийт пассив;
- Гадаад валютын актив / Нийт актив;
- Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл + Гадаад валютын хадгаламж / Гадаад валютын харилцах хадгаламж;
- Гадаад валютын цэвэр зээл / Нийт актив;
- Гадаад валютын хөрвөх актив / Гадаад валютын харилцах хадгаламж;
- Том харилцагчдын харилцах, хадгаламж / Харилцах хадгаламж;
- Засгийн Газрын харилцах, хадгаламж / Харилцах хадгаламж;
- Бусад харьцаа үзүүлэлтүүд.

ГАДААД ВАЛЮТЫН ХӨРВӨХ ЧАДВАРЫН УДИРДЛАГА

Валютын ханш эсвэл тухайн валютын балансын бүтэц өөрчлөгдөх үед банкны гадаад валютын хөрвөх чадварт өөрчлөлт гардаг. Валютын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гол түлхүүр нь гадаад валютаар олгох эзэлийн хэмжээг тухайн валютаар татсан эх үүсвэртэй уялдуулах явдал юм.

ТӨВЛӨРӨЛ БАГАТАЙ БАГЦ БУЮУ ХӨРӨНГИЙН ТАРААН БАЙРШУУЛАЛТ

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог. Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат хадгаламж, харилцах болон харилцагчдын оновчтой түүврээс (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.



ХӨРВӨХ ЧАДВАРЫН СТРЕСС ТЕСТ

Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас банкны хөрвөх чадварт үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор тусгайлсан болон системчилсэн стресс сценаруудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөлмүүдийг хийдэг. Сценарууд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдал (жишээ нь нэг банк хүндэрсэн нь түүхэн үйл явдал бол үүнээс системд үзүүлэх нөлөөллийг тооцоолох нь төсөөлсөн үйл явдал юм)-ын аль алинд суурилж болох бөгөөд стресс тестийн үр дүнгүүд нь хөрвөх чадварын зорилтот түвшингүүдийг тодорхойлох, төлөвлөхөд хамгийн зөв, оновчтой өгөгдлүүд болдог.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эдийн засаг зогсонги байдалд орсонтой холбоотойгоор банк хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ нь хөрвөх чадварын хүндрэлийг хохиролгүйгээр даван туулахуйц түвшний итгэлцлийг зах зээлд бий болгох, хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн цогц төлөвлөгөө бөгөөд хямралын үед баримтлах тодорхой стратегид суурилсан, хямралыг урьдчилан мэдээлэх өргөн хүрээтэй үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Урьдчилан мэдээлэх үзүүлэлтүүд нь тодорхой давтамжтайгаар, нарийвчлалын өндөр түвшинд хянагдан шинэчлэгддэг бол хямралын эсрэг стратеги нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохион байгуулагдаж, дотоод гадаад харилцаа, хөрвөх чадвар болон нөхцөл байдлын шаардлагаар бий болох нэмэлт мэдээллийн шаардлагуудыг тусгасан байдаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ гэх мэт зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн сөрөг өөрчлөлтийн нөлөөгөөр банкинд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк арилжааны болон арилжааны бус багцын аль алинаас нь зах зээлийн эрсдэлд өртөж болох бөгөөд энд банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа ч хамаардаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зах зээлийн эрсдэлийн ерөнхий хязгаарлалт болон түүнд агуулагдах үзүүлэлт нэг бүрийн нарийвчилсан хязгаарлалтуудыг тогтоож, хэрэгжилтийг Актив Пассивын Хороо хянадаг. Энэхүү хяналт нь банк одоо болон ирээдүйд хүү, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох эрсдэлийн нийт багцыг тодорхойлох, тогтмол хянах зарчмаар хийгддэг.

Хөрөнгийн Удирдлагын газрын захирал Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Актив Пассивын Хорооноос тогтоосон бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын төрлүүд, арилжааны хэлцлүүд болон санхүүгийн хэрэгслүүдийн хувьд тавигдсан хязгаарлалтуудыг үйл ажиллагаандаа мөрддөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгэж ирсэн. Эрсдэлийн Удирдлагын газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож үйл ажиллагаа Актив Пассивын Хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

ХҮҮГИЙН ЭРСДЭЛ

Банкны арилжааны бус багцаас урган гардаг зах зээлийн гол эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс банкны ашиг, эсвэл өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөлөл буюу хүүгийн эрсдэл юм. Бид дараах шалтгаануудын улмаас хүүгийн түвшний эрсдэлд өртдөг.

- Хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлэгдэх эсвэл төлөгдөх хугацаа ялгаатай байх (жишээ нь, хөрөнгө эх үүсвэрээс хурдан хугацаанд дахин үнэлэгддэг тохиолдолд хүү буурах нь ашгийг бууруулна);
- Хөрөнгө, эх үүсвэр ижил хугацаанд ялгаатай дүнгээр дахин үнэлэгдэх (жишээ нь, зах зээл дэх хүүгийн түвшин бууралтаас бага дүнгээр бууруулах);
- Урт богино хугацаанд зах зээлийн хүүгийн түвшин ялгаатай дүнгээр өөрчлөгдөх (жишээ нь, өгөөжийн муруй шинээр олгогдож буй зээлийн өгөөж болон эх үүсвэрийн зардалд өөрөөр нөлөөлөх);
- Хүүгийн түвшний өөрчлөлтөөс хөрөнгө, эх үүсвэрийн үлдсэн хугацаа уртсах эсвэл богиносх (жишээ нь, хэрэв урт хугацаат моргейжийн хүү огцом буурвал моргейж төлөвлөсөн хугацаанаас эрт ихээр төлөгдөж, орлого буурна).

Хүүгийн түвшний эрсдэлийг хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлгээний зөрүүгээр үүссэн хүүгийн мэдрэмжийн зөрүү дүнг шинжлэх замаар тооцоолж бодно. Доорх хүснэгтэд хүүгийн түвшний болзошгүй өөрчлөлтөөс орлогын тайланд үзүүлэх нөлөөллийг оны эцсийн өгөгдлүүдийг суурилан үзүүлээ.



	Хүүгийн өөрчлөлт	Ашигт үзүүлэх нөлөө
2009	+120	-4.06 %
2009	-120	4.06 %
2008	+120	-3.96 %
2008	-120	3.96 %

ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЭЛ


Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс болдог. Арилжааны багцаас хүлээх эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хэмжээ, зах зээл дэх хөрвөх чадвар болон үнийн өөрчлөлтөөс голлон үүсэх бөгөөд эрсдэлийн үндсэн хүчин зүйлүүд нь хүүгийн түвшин, ханш, хувьцааны үнэ юм.

Банкны арилжааны үйл ажиллагааны гол цөм нь харилцагчдад өрсөлдөхүйц үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэх буюу харилцагчид чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнээс гадна банк ашиг олох зорилгоор өөрөө янз бүрийн арилжааг хийдэг бөгөөд тухайлбал, зах зээлийн давуу байдлаа ашиглан авах, зарах үнийн зөрүүгээр ашиг олох зорилгоор валютын арилжаа хийх, хоорондоо холбоотой өөр өөр зах зээлийн төгс бус байдлаас ашиг олох зорилгоор позици үүсгэх, ирээдүйд давуу тал олох зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмших гэх мэт.

Бизнесийн үйл ажиллагааныхаа явцад зах зээлийн эрсдэлтэй холбогддог банкны бүтцийн бүхий л нэгжүүд банкны арилжааны бодлогыг дагаж мөрдөх ёстой. Зах зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь нарийвчлан тогтоосон, хатуу хязгаарлалтууд бөгөөд эдгээр нь дилерийн эрх хэмжээ гэх мэт эрсдэлийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүдийг бүхэлд нь тогтоосон байдаг. Хязгаарлалтууд зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээнүүдийг арилжааны бодлогод мөн тусгасан байдаг.

Бид зах зээлийн эрсдэлийг тооцоолохдоо гурван төрлийн VaR (Value at Risk) аргыг ашигладаг. VaR нь тодорхой хугацааны хязгаарт багцын зах зээлийн үнэлгээнд гарч болох боломжит сөрөг өөрчлөлтийг өгөгдсөн итгэх түвшинд тооцоолдог техник юм. Бид Төв банкны зохистой харьцааны шаардлагын дагуу VaR-г 10 хоногийн хугацаанд 90 хувийн итгэх засварт тооцоолохын зэрэгцээ 1 өдрийн дотор 99 хувийн итгэх засварт тооцоолон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа ашигладаг.

Түүнчлэн VaR аргаар тооцоологдох боломжгүй алдагдлыг тодорхойлох зорилгоор стресс тестийг хийдэг. Доорх зурагт 99 хувийн итгэх засварт, 1 өдрийн хугацааны хязгаартайгаар, өмнө дурдсан 3 төрлийн VaR аргаар хийсэн тооцооллын үр дүнг нэгтгэн харуулав. EVT VaR нь стресс тестийн үр дүнг харуулав.





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дүрэм журам, системийн нийцгүй байдал эсвэл үл хэрэгжилт, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр банкинд шууд ба шууд бусаар учирч болох эрсдэл юм.

Бид үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой тодорхойлох, хянаж удирдах зорилгоор холбогдох бодлого, стандарт, аргачлалуудыг боловсруулан хэрэгжүүлж байна. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Салбар нэгжүүдийн үйл ажиллагаанд тавигдах хянах, шалгах механизмуудын сайжруулалт;
- Харилцагчийн данс нээх үйл ажиллагааны стандартчилал, мэдээллийг бүрэн бүрдүүлэх, архивлах үйл ажиллагааны сайжруулалт;
- Зээлдэгчийн скоринг хийх арга барилын сайжруулалт;
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад мэдээллийн системийг 100 хувь ашиглах;
- Албан тушаал хуваарилалт болон буцааж татах ажиллагааны сайжруулалт;
- Ажилчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын сайжруулалт;
- Мэдээллийн системийн сайжруулалт;
- Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулах, турших;
- Бизнесийн үе шат бүр дэх хариуцлага, хяналтын систем;
- Хүчирхэг дотоод хяналтын орчин;
- Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах боломж бүхий үр ашигтай бүтэц, зохион байгуулалт;
- Эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах үйл явцыг бүхэлд нь агуулсан оновчтой үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо.

Түүнчлэн Банк зарим эрсдэлийг гуравдагч этгээд буюу даатгалын байгууллагад шилжүүлж ажилласан бөгөөд 2009 онд банкны хөрөнгийг даатгалд бүрэн хамруулж, мэргэжлийн хариуцлагын даатгалыг нэвтрүүлэн ажилласан.

МЭДЭЭЛЛИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Мэдээллийн эрсдэл гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах, өөрчлөх, задлах, устгах замаар мэдээллийн үнэн зөв, найдвартай, хэрэглэхүйц байдлыг алдагдуулах эрсдэл юм. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд хамаарах онцлог үйл ажиллагаа. Энэ нь зөвхөн банкны мэдээллийн эх сурвалжуудыг янз бүрийн халдлагаас хамгаалаад зогсохгүй бизнесийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн тасралтгүй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх болон төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд ч чухал үүргийг гүйцэтгэдэг. Бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхдээ олон улсын туршлагауд болон холбогдох хууль, дүрэм, журмуудыг баримтлан ажиллаж байна.

Үйл Ажиллагааны Эрсдэлийн Удирдлагын хэлтэс нь хэрэглэгчийн үйлдэл, сервер болон банкны үндсэн програмын хэвийн ажиллагаанд хяналт тавих эрсдэлийн хяналтын програмын тусламжтайгаар өдөр тутмын үйл ажиллагаагаа гүйцэтгэж байна.

БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент нь урьдчилж хараагүй элдэв осол, саатлын улмаас банкны бизнесийн хэвийн үйл ажиллагаа тасалдахад түүнийг богино хугацаанд хэвийн байдалд нь оруулах, системийн ажиллагааг бүрэн сэргээх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг. Бид осол, саатлын үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг боломжит түвшинд хамгийн богино хугацаанд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг зорин ажиллалаа.

Бид осол саатлын үеийн хүндрэлүүдийг удирдах үйл ажиллагааг зохион байгуулалттай, хянагдахуйц хэлбэрт оруулах зорилгоор бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулсаар ирсэн.

Үйл Ажиллагааны Эрсдэлийн Удирдлагын хэлтэс нь банкны бизнесийн тасралтгүй байдлыг хянаж удирдах, уг төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүргийг гүйцэтгэхээс гадна уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ослын үед ажиллах баг” болон “Бизнесийн үйл ажиллагааг сэргээх баг”-уудтай нягт хамтран ажиллаж байна.



ЛУЙВРЫН ШИНЖТЭЙ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Гүйлгээний үйл явцад гарсан алдаатай үйлдлүүд, банкны хэмжээний залилан, түүнтэй төсөөтэй үйлдлүүдийг хянах, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд луйврын шинжтэй эрсдэлийн менежмент ихээхэн чухал үүргийг гүйцэтгэдэг.

Банк луйврын шинжтэй үйлдлүүд нь бизнесийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэдгийг хатуу ухамсарласан байдаг учраас луйврын шинжтэй эрсдэлийн менежментийг Компанийн засаглалын хамгийн чухал элементийн нэгэнд оруулсан байдаг.

Банк нь данс бүртгэлийн алдаа, залилан гэх мэт луйврын шинжтэй бүхий л төрлийн үйл ажиллагаанаас сэргийлэхээр хичээнгүйлэн ажиллаж байгаа ба банкны үйл ажиллагааны бүхий л түвшинд бодлого журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, хуйвалдан мэхлэх үйлдлийн эсрэг болон луйврын шинжтэй үйлдлийн эсрэг тэмцэх бодлого, стратегийг иж бүрэн утгаар нь боловсруулан хэрэгжүүлсэн. Луйврын шинжтэй үйлдлүүдийн улмаас үүсэх алдагдлыг бууруулах, ийм төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүд болон гэмт хэрэг хийж болзошгүй этгээдийг илрүүлэх зорилгоор банкны өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар хянаж байна.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Бодлогын хэрэгжилтийн эрсдэл нь банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам, эрхзүйн баримт бичиг, гэрээ, стандартыг мөрдөөгүйгээс банкны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, нэр хүндийн эрсдэлд орохыг хэлдэг. Монгол Улс дахь дотоодын эрх зүйн зохицуулалтаас гадна олон улсын холбогдох гэрээ, конвенци, хуулиуд, ёс зүйн кодоод нийцэж ажиллаж буй байдалд хяналт тавьж, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох, нэр хүндээ алдах зэрэг эрсдэлээс хамгаалах үүднээс Бодлогын Хэрэгжилтийн нэгж ажиллан, банкны хэмжээний эрх зүйн бичиг баримтуудад байнгын хяналт тавьж ажиллаж ирсэн.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомж нь санхүүгийн байгууллагуудаас харилцагчдынхаа мэдээллийг албан ёсоор тодорхойлж, тодорхой түүхүүдийг хадгалахын зэрэгцээ мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэхийг шаарддаг. Банк нь өөрчлөгдөж буй хууль эрхзүйн орчин нөхцөлд тохируулан бодлого, түүнийг хянах механизмаа сайжруулах замаар мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаагаа илүү хүчирхэгжүүлж ажиллалаа. Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого журам, түүний хяналтын механизмд “Know your customer” хяналтын зарчим, ажилтнуудад мэдлэг олгох сургалт, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, түүнийг тайлагнах, эрсдлийг тодорхойлох үйл ажиллагаанууд хамаарагдаж байна. Дэлгэрүүлэн хэлбэл, банкны өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих ажлыг автоматжуулан, өндөр мөнгөн дүнтэй болон хэвийн бус гүйлгээний талаарх мэдээллийг банкны сэжигтэй гүйлгээг хянах систем болон дотоод журмаараа илрүүлэхэд анхаарал тавин ажилласан. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанд холбогдох тайлан мэдээг тогтмол гаргаж, хамтран ажиллаж ирэв. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, үүнтэй холбоотой банкны бодлого, журмын талаар ажилтан бүр мэдлэгтэй байх, шинэчлэгдсэн мэдээллийг цаг тухайд нь авах, өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс холбогдох сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Мөн түүнчлэн банкны үйл ажиллагааны нэгжийн ажилтнууд, дотоод хяналтын үүрэг бүхий ажилтнууд болон Хувийн банкны албаны ажилтнууд энэ чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамрагдлаа.

Бид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, олон улсын тэргүүн туршлагаас суралцах чиглэлээр гадаадын корреспондент банкууд болон бусад банкуудтай нягт хамтран ажилладаг.

АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ажилтнууд, харилцагчид болон бусад хамтран ажиллагсадын аюулгүй байдлыг хангах нь банкны анхаарал хандуулах асуудлуудын тэргүүн эгнээнд тавигдаж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлд холбогдох нэгжүүд идэвхтэй ажиллаж байна.

Өнгөрөгч 2009 онд банк нь ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дүрэм журмуудын хэрэгжилтийг хангуулах чиглэлд голлон анхаарав.



НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Банк нь тайлант онд нийгмийн сайн сайхны төлөөх удаан хугацааны уламжлалт арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, спорт, соёл урлаг, нийгэм эдийн засгийн салбарыг дэмжин ажиллалаа.

Тайлант онд Банкнаас хэрэгжүүлсэн нийгэмд чиглэсэн арга хэмжээнүүдийг дурьдвал:

- Сонгодог урлагийг хөгжүүлж, дуурь болон бүжгэн жүжгийн хөгжлийг дэмжих үүднээс Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын ивээн тэтгэгчээр үргэлжлүүлэн ажиллав;
- Оюутны Тэтгэлэгт Хөтөлбөрийг 7 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж эссе, шалгалт, ярилцлагын үр дүнд шалгарсан 100 оюутанд тэтгэлэг олгов;
- Монгол Улсад Олимпийн спортыг хөгжүүлэх, Олимпизмийг дэмжих зорилгоор Монголын Үндэсний Олимпийн Хорооны албан ёсны түншээр ажиллахаар ахин сонгогдлоо;
- Монголбанктай хамтран Оюутны Эрдэм Шинжилгээний бага хурлыг 8 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, 14 их дээд сургуулийн 80 гаруй оюутан оролцлоо;
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулан төлбөрийн картын хэрэглээ болон түүний ашиг тусын талаар “Төлбөр тооцооны ирээдүйн чиг хандлага” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа;
- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутнуудад тав тухтай суралцах нөхцөл бололцоог нь хангасан сүүлийн үеийн техник технологи бүхий номын санг иж бүрэн тохижуулан хүлээлгэж өглөө;
- Ажилтнууд маань өнгөрсөн оны 7 сарын 17-оос 18-ны өдрүүдэд болсон үерийн улмаас орон гэрээ алдсан айл өрхүүдэд туслах зорилгоор өөрсдийн нэг өдрийн цалингаа хандивлах санаачлага гаргаж, тэдгээр зовлонд нэрвэгдсэн айл өрхөд гэр ахуйн хэрэглэлээр тусламж үзүүллээ;
- Дэлхийд тэргүүлэгч Мастеркарт Ворлдвайд байгууллагатай хамтран картаар үйлчлэгч байгууллагууд болон харилцагчдынхаа дунд спортын нөхөрсөг тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

НОГООН БИЗНЕС, НОГООН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ

Голомт банк Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай “Ногоон Бизнес”, “Ногоон эдийн засаг”-ийг дэмжиж, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Түүнчлэн донор байгууллагууд, хамтран төсөл хэрэгжүүлж буй олон улсын байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааны хүрээнд дотоодын бизнес эрхлэгчдийг ногоон эдийн засагт хувь нэмэр оруулах, байгаль орчинд таатай үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг болж байна. Тухайлбал:

- Нидерландын Засгийн Газраас санхүүжилттэй Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ногоон Зээлийн Баталгааны Сантай хамтран “Эрчим хүчний хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” болон “Жижиг дунд бизнесийг дэмжих, зээлийн баталгаа гаргах хөтөлбөр” хэрэгжүүлж байна;
- Банк нь БОАЖЯ-ны Цэвэр Хөгжлийн Механизмын Үндэсний Товчоо, Германы Сэргээн Босголтын Банкны Нүүрсхүчлийн Хийн Сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж агаарын бохирдол, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр Цэвэр Хөгжлийн Механизмийн төслүүдийг хэрэгжүүлж байна;
- Банк нь Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банктэй хамтран байгаль орчинд ээлтэй хувийн салбарын бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл”-ийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүжилтийг олгож байна.

Банк нь нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж байгаа онцгой хувь нэмрээ үнэлүүлж Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Шилдэг нийгмийн хариуцлагатай байгууллага” шагналыг 2009 онд дахин хүртлээ.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГУУЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД:

Хадгаламж харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- “Алтан түлхүүр” хүүхдийн хадгаламж
- Байгууллагын хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Байгууллагын зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Зээлийн шугам
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Хүнд машин, механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн зээл
 - Банк бус санхүүгийн байгууллагын зээл
 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээл
 - Ашигт малтмалын зээл
 - Импортын зээл
 - Аккредитив
 - Ногоон зээл
- Төслийн зээл

Баталгаа

- Тендерийн баталгаа
- Төлбөрийн баталгаа
- Гүйцэтгэлийн баталгаа

Гадаад валютын арилжаа

Картын үйлчилгээ

- МастерКарт карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Стандарт (дотоодын, олон улсын)
 - Маэстро (оюутны)
 - Бэлгийн карт

- Хосолсон валюттай карт (төгрөг/доллар, төгрөг/евро)

- Виза карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн(дотоодын, олон улсын)
 - Виза электрон(оюутны)
 - Бэлгийн карт
- Американ экспресс картаар үйлчлэх
- Юаний карт

Ко-брэнд карт

- МИАТ миллэйж карт
- Air Network карт
- Chamber's Виза алтан карт

Е-банкны үйлчилгээ

- Интернет банк
- Электрон банк
- SMS банк
- SMS-ээр мэдээлэх үйлчилгээ
- Е-биллинг
- Мобайл банк
- Дуудлага хүлээн авах төв
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Мөнгөн шилжүүлгийг факсаар баталгаажуулах үйлчилгээ
- Дансны хуулга, тодорхойлолт гаргах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ



ИРГЭДЭД:

Хадгаламж харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- “Алтан түлхүүр” хүүхдийн хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Жижиг дунд бизнесийн зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Зээлийн шугам
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Хүнд машин, механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн зээл
 - Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх зээл
 - АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл
 - Импортын зээл
 - Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн жижиг дунд бизнесийг дэмжих зээл
- Хэрэглээний зээл
 - Өрхийн зээл
 - Орон сууц засварлах зээл
 - Цалингийн зээл
 - Авто машины зээл
- Картны зээл
 - Сургалтын зээл
 - Хадгаламж барьцаалсан зээл
 - Тэтгэвэрийн зээл
 - Шуурхай зээл
- Орон сууцны зээл

Картын үйлчилгээ

- Мастеркарт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн (дотоодын, олон улсын)
 - Маэстро (оюутны)

- Бэлгийн карт
- Нандин карт
- Хосолсон валюттай карт (төгрөг/доллар, төгрөг/евро)

- Виза карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн(дотоодын, олон улсын)
 - Виза электрон(оюутны)
 - Бэлгийн карт
- Американ экспресс картаар үйлчлэх
- Юаний карт

Ко-брэнд карт

- МИАТ миллэйж карт
- Air Network карт
- Chamber's Виза алтан карт

Е-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Электрон банк
- SMS банк
- SMS-ээр мэдээлэх үйлчилгээ
- Е-биллинг
- Мобайл банк
- Дуудлага хүлээн авах төв
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Мөнгөн шилжүүлгийг факсаар баталгаажуулах үйлчилгээ
- Дансны хуулга, тодорхойлолт гаргах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ



БАНКНЫ САЛБАР НЭГЖҮҮДИЙН ХАЯГ

ГОЛОМТ БАНКНЫ ТӨВ АЛБА

Бодь цамхаг, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 210620А
Утас: +(976-11) 311971, 311530
Факс: +(976-11) 313155, 312307
И-мэйл: mail@golomtbank.com
Вэб: <http://www.golomtbank.com>

УЛААНБААТАР ХОТОД БУЙ САЛБАР, НЭГЖҮҮД

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Төв Салбар	Худалдааны гудамж 6/2. Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-310759, 313155 Факс: +(976-11)-326231
Сансар Салбар	Баянцээл худалдааны төв, 15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-456980 Факс: +(976-11)-456829
Нисэх тооцооны төв	“Чингэс хаан” нисэх онгоцны буудал, Хан-уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-283205 Факс: +(976-11)-283205
100 айл тооцооны төв	Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, 7-р хороо, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350542 Факс: +(976-11)-350544
Ард Салбар	Бага тойруу гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-320712 Факс: +(976-11)-330436
Солонго Салбар	Нацагдоржийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-320814 Факс: +(976-11)-318479
Саппоро Салбар	1-р хороолол, Сонгино -Хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-681267 Факс: +(976-11)-680367
Москва Салбар	Голомт банк байр, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-305419 Факс: +(976-11)-368602
Гааль Тооцооны төв	Хотын Гаалийн газрын байр, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-242943 Факс: +(976-11)-242943
Багануур Тооцооны төв	Холбооны байр, Багануур дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-01-21)-22333 Факс: (976-01-21)-20818
Зээлийн төв	Энхтайвны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-330072 Факс: +(976-11)-330621
Голомт хотхон Салбар	Үндсэн хуулийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-322943 Факс: +(976-11)-322943
Цамбагарав Тооцооны төв	Цамбагарав худалдааны төв, 1-р хороолол, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-680762 Факс: +(976-11)-680763
Цэцээ гүн Тооцооны төв	“Цэцээ гүн” сургуулийн байр, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-316395 Факс: +(976-11)-316395
Тэди Тооцооны төв	Самбуугийн гудамж-46, 5-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-325970 Факс: +(976-11)-325970
120 мянгат Тооцооны төв	120 мянгат үйлчилгээний төв, 1-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-70130080
Энхтайваны гүүр Тооцооны төв	Тээвэр үйлчилгээний төв, Чингэсийн өргөн чөлөө-11, 2-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-315949
Тамир Тооцооны төв	Ард Аюушийн гудамж, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-304959 Факс: +(976-11)-304959
Нарантуул Тооцооны төв	Нарантуул Олон Улсын Худалдааны Төв, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-457018
Их дэлгүүр Тооцооны төв	4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-311530, 311971 Факс: +(976-11)-70111352
Чандмань Тооцооны төв	Чандмань төв, Лениний музей, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-70120520 Факс: +(976-11)-70120520
Баянзүрх Тооцооны төв	15-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-458250 Факс: +(976-11)-462892
Сансар зээлийн төв	Баянцээл худалдааны төв, 15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-458898 Факс: +(976-11)-456829



Номин Тооцооны төв	Улсын Их Дэлгүүр, Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-313232 Факс: +(976-11)-314242
Central tower Тооцооны төв	Central tower 4-р давхар, Сүхбаатарын талбай, 4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-326474 Факс: +(976-11)-326494
32-ын тойрог Тооцооны төв	Сансар-32 худалдааны төв 2-р давхар, 32-ын тойрог, 12-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-77443232 Факс: +(976-11)-77443131
Сонгино хайрхан Тооцооны төв	Жавхлант компаний байр 1-р давхар, 19-р хороо, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-636205 Факс: +(976-11)-636217
Моннис Тооцооны төв	Моннис цамхаг 4-р давхар, 4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-321273 Факс: +(976-11)-321273

ОРОН НУТАГТ БУЙ САЛБАР ТӨВҮҮД

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, Факс
Дорнод Тооцооны төв	Зуун Суварга компанийн байр, 7-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976-01-582)-22703 Факс: +(976-01-582)-22702
Замын-Үүд Тооцооны төв	Замын-Үүд вокзал, 2-р давхар, 1-р баг, Замын-Үүд сум, Дорноговь аймаг	Утас: +(976-025-245)-43773 Факс: +(976-025-245)-43773
Орхон Салбар	Амарын талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-25100 Факс: +(976-01-352)-22510
Орхон-Пирамид Тооцооны төв	Согоот баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-23300 Факс: +(976-01-352)-23300
Орхон-Зээлийн Тооцооны төв	Орхон-Чандмань компанийн байр, 2-р давхар, Уурхайчин баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-32100 Факс: +(976-01-352)-32100
Дархан Салбар	Нийгмийн даатгалын хэлтсийн байр, 13-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976-01-372)-27136 Факс: +(976-01-372)-27136
Дархан Зээлийн төв	Мандах Баясах компанийн байр, 8-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976-01-372)-27136 Факс: +(976-01-372)-27136
Хөвсгөл Тооцооны төв	Нэмэн компанийн байр, 3-р хороо, Мөрөн сум, Хөвсгөл аймаг	Утас: +(976-01-382)-21474 Факс: +(976-01-382)-21474
Өмнөговь Тооцооны төв	3-р баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-532)-23991 Факс: +(976-01-532)-23990
Ховд Салбар	Монголбанкны байр, 1-р давхар, Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976-01-432)-22195 Факс: +(976-01-432)-22195
Баян-Өлгий Салбар	Соёлын төв, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976-01-422)-22001 Факс: +(976-01-422)-22001
Дорно-Говь Тооцооны төв	Үлэмж худалдааны төв, 1-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976-01-522)-42792 Факс: +(976-01-522)-42792
Цогтцэций Тооцооны төв	№1-7, Ямаан хүрэн баг, Цогтцэций сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-532)-26520
Гурван тэс Тооцооны төв	Хурд супермаркет, 1-р давхар, Гурван Тэс сум, 4-р баг, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-534)-42266 Факс: +(976-01-534)-42244
Сэлэнгэ Тооцооны төв	Монгол даатгалын байр, 1-р давхар, Сүхбаатар сум, Сүхбаатар аймаг	Утас: +(976-01-362)-22318 Факс: +(976-01-362)-22318

ГАДААДАД БУЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Бээжин дэх төлөөлөгчийн газар	10E, CITIC building Tower A19, Jianguomen Dajie, Beijing, China 100004	Утас: +(86-10)-65033876 Факс: +(86-10)-65923727 Гар утас: +(86-139)-11737254 И-мэйл: golomt@public2.bta.net.cn
Лондон дахь Төлөөлөгчийн газар	27 Throgmorton Street, London EC2N 2AQ, United Kingdom	Утас: +(44-0)-20 7382 9900 Факс: +(44-0)-20 7382 9988 И-мэйл: jeremy.denton-clark@gbw.com И-мэйл: mail@gbw.com



ГОЛОМТ БАНК

ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТИЙН ТАЙЛАН

